

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГАА

2024
СУДАЛГААНЫ
ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ
ЗОХИЦУУЛАЛТ НЬ ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД
ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ ХҮНИЙ
НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН
ЭСРЭГ КОНВЕНЦ БОЛОН ТҮҮНИЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛД
НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХ ТАЛААР ХУУЛИЙН ХОЛБОГДОХ
ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ
АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТ НЬ ЭРҮҮДЭН ШҮҮХ
БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ,
ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН
ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ БОЛОН ТҮҮНИЙ
НЭМЭЛТ ПРОТОКОЛД НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХ ТАЛААР ХУУЛИЙН
ХОЛБОГДОХ ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

(Судалгааны тайлан)

ННА - 67
ДАА - 340
Ц- 945

Зөвлөх профессор:

Жүгнээгийн Амарсанаа

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D),
Профессор, Монгол Улсын Гавьяат хуульч

Судлаачдын баг:

Чойжилын Нямсүрэн

Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор

Батсайханы Эрдэнэбат

Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Ширчингийн Номин-Эрдэнэ

Шинжлэн магадлахуйн ухааны доктор (Ph.D)

Занахүүгийн Сансарзолбоо

Докторант

Туяагийн Амарзаяа

Докторант

ISBN 978-9919-0-2728-5

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	4
Өмнөх үг	5
Удиртгал	7
НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	9
1.1. Үнэлгээ хийх үндэс, хэрэгцээ шаардлага	9
1.2. Үнэлгээ хийх хүрээ	12
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	13
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	15
1.5. Мэдээлэл цуглуулах арга	15
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	16
2.1. Баримт бичгийн судалгаа	16
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	19
3.1. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол ба Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн зорилт	19
3.2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хараат бусын баталгаа	21
3.3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүрэг, хамрах хүрээ	36
3.4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бүрэн эрхийн баталгаа	38
3.5. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зөвлөмж	40
3.6. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлан	41
3.7. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн ба түүний нэгжийн бусад этгээдтэй харьцах харилцааны зохицуулалт	41
3.8. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хориглох зүйл	43
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	44
Зөвлөмж	51
ТАВ. ЯАГААД ЭРҮҮДЭН ШҮҮЛТИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛД ДОТООДЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙГ НИЙЦҮҮЛЭХ ЁСТОЙ ВЭ?	63
Зөвлөмж	72
ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН ХОЛБОГДОХ ХУУЛЬ БА ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН НИЙЦЭЛ	73

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц
Нэмэлт протокол	Эрүүдэн шүүхийн болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол
ЭШУС Дэд хороо	НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо
ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн
ЭШУС үндэсний ажиллагаа	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ХЭҮКтХ	Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ШШГтХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

ӨМНӨХ ҮГ

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний хараат бус тогтолцоог төлөвшүүлэх нь хүний эрх эрх чөлөөний нэг баталгаа төдийгүй төр, төрийн байгууллага, албан тушаалтан, алба хаагчаас хууль дээдлэх, шударга ёс, энэрэнгүй ёсны зарчмыг хэрэгжүүлэх, тэдгээрийн нэр хүнд, иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанар шууд хамаарах нь зүй ёсны хэрэг.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол улсын нутаг дэвсгэр дээр түр болон байнга оршин суугаа иргэн, хүн нь “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй... Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэж заасан нь эрүү шүүлтээс ангид байх, халдашгүй байх эрх, эрх чөлөөг хамгаалах, тодруулбал “эрүү шүүлтээс ангид байх эрх” нь ямар ч тохиолдолд үл хязгаарлагдах, хүний онцгой үндсэн эрх мөн.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейгээс 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 39/46 дугаар тогтоолоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүмүүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг баталж, 2001 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Монгол Улсын Их Хурал соёрхон баталсан.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тавиндолдугаар чуулганы 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн A/Res/57/199 дүгээр тогтоолоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт Протоколыг баталж, 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хурал соёрхон баталсан баталсан юм. Протоколын зорилго нь Олон улсын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний бие даасан байгууллага хараат бусаар ажиллах боломжийг олгох буюу Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бий болгоход оршино.

Эдгээр олон улсын гэрээнд нэгдэн орсон нь манай улсын хувьд олон улсын өмнө хэнийг ч эрүүдэн шүүж эрх, эрх чөлөөг нь зөрчихгүй байх, эрүүдэн шүүхээс ангид байх эрхийг хангах, хамгаалах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэг хүлээсний нотолгоо мөн. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дөрөв дэх хэсгийн “Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэчлэл”-ийн 4.4.12-д “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.” гэж заасан.

Дани улсын Копенхаген хотноо 2023 оны 11 дүгээр сарын 6-аас 8-ны өдрүүдэд болсон Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын олон улсын 14 дүгээр хурлаар баталсан “Эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх дэлхий нийтийн төлөвлөгөө –Тунхаглал”-ын В. Урьдчилан сэргийлэх. а) Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколыг соёрхон батлах, бие даасан, хангалттай нөөцтэй Үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг томилохыг дэмжинэ” гэж зааж, эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр зүй бус харьцах явдлын эрсдэл дэлхий даяар нэмэгдэж байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх үүрэг улс үндэстнүүдэд хүлээлгэсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, мөн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан.

Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нэгдэн орж, Улсын Их Хурал тус тус соёрхон баталсан билээ.

Иймд соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсон үүргийнхээ дагуу дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх үүрэгтэй.

Түүнчлэн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасан тул Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол дотоодын хууль тогтоомжтой адил үйлчилнэ.

Хараат бус эрдэмтэн судлаачдын багаас хийсэн судалгааны үр дүнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний өнөөгийн тогтолцоо нь олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, бие даасан үр дүнтэй урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, Конвенцод заасан хяналт шинжилгээ хийх үйл ажиллагааг хязгаарласан ялангуяа хүний нөөц, санхүү болон үйл ажиллагааны бие даасан байдлыг үгүйсгэх хандлага байгааг тэмдэглэх хэрэгтэй юм.

Энэ судалгаа нь хууль тогтоогч, хэрэглэгч, мөн хүний эрхийг сонирхон судалдаг эрдэмтэн багш, судлаач нарт бага боловч хувь нэмэр болно гэдэгт итгэж байна.

**Академич, Доктор, Профессор,
Монгол Улсын Гавьяат хуульч**



Жүгнээгийн Амарсанаа

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 12 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоол батлагдсан¹.

Тус тогтоолын 1 дэх хэсгээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохицуулалтууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар болон хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, танилцуулахыг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороонд даалгасан.

Уг тогтоолын хэрэгжилтийг хангах УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос өгсөн чиглэлийн хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсээс Хараас бус судлаачдын багаар хуулийн хэрэгжилтийн үр, дагаварт үнэлгээ, дүн шинжилгээ хийх нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан. Тус нээлттэй судалгааны ажил гүйцэтгэхэд манай судлаачдын баг шалгарч, Хүний эрхийн үндэсний комиссын Тамгын газрын даргатай 2024 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн Ажил гүйцэтгэх гэрээ №ХЭҮК (2024)12 байгуулсан болно.

Судалгаачдын багт Зөвлөх профессороор Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, Монгол Улсын Гавьяат хуульч Жүгнээгийн Амарсанаа, Судалгааны багийн ахлагчаар Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Чойжилын Нямсүрэн, гишүүдээр Хууль зүйн ухааны доктор (Ph.D) Батсайханы Эрдэнэбат, Шинжлэн магадлахуйн ухааны доктор (Ph.D) Ширчингийн Номин-Эрдэнэ, докторант Занахүүгийн Сансарзолбоо, докторант Туяагийн Амарзаяа нар ажиллав.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар болон хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр

¹ Эрх зүйн акт дэлгэрэнгүй (legalinfo.mn)

дагаварт Хууль тогтоомжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр “Аргачлал батлах тухай” тогтоолын 6 дугаар хавсралтад заасан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”² /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалтын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколтой нийцэж байгаа эсэх болон холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой бөгөөд хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.

² Эрх зүйн акт дэлгэрэнгүй (legalinfo.mn)



НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭС, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, 1987 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц³ /цаашид “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц” гэх/-д Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталсан⁴.

Монгол Улсын Их Хурлаас Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол⁵ /цаашид “Нэмэлт протокол” гэх/-ыг батлах тухай хуулийг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр баталснаар 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль /цаашид “ХЭҮКтх” гэх/-д нэмэлт өөрчлөлт оруулж, хуулийн 7 дугаар бүлэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зохицуулалтыг хуульчилсан⁶.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлд “Энэхүү Конвенцын зорилгын дагуу “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолт нь хуулийн дагуу авах шийтгэл, арга хэмжээ, түүнээс үүдэн буюу холбогдон үүсэх зовлон, шаналалд хамаарахгүй” гэж “эрүүдэн шүүх” үйлдлийг тодорхойлоод,

³ ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ (legalinfo.mn)

⁴ КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ /Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенц/ (legalinfo.mn)

⁵ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. Хуудас 411-440

⁶ МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ (legalinfo.mn)

⁷ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц. 385 дахь тал.

- Конвенцын 2 дугаар зүйлийн “Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн болон бусад арга хэмжээг авна⁸” гэсэн,
- 11 дүгээр зүйлийн “Оролцогч улсууд эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор түүний харьяа нутаг дэвсгэрт аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон хүмүүсийг байцаахтай холбогдсон журам, заавар, арга хэрэгсэл, түүнчлэн тэднийг хянан харгалзах, тэдэнтэй харьцах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд шат дараалсан хяналт тавина⁹” гэсэн,
- 16 дугаар зүйлийн “Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ 1 дүгээр зүйлд тодорхойлсон эрүү шүүлтэд тооцогдохгүй төрийн албан тушаалтан буюу албаны үүрэг гүйцэтгэж буй бусад этгээд, тэдгээрийн өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр үйлдэгдэх хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх бусад үйлдлээс сэргийлэх үүрэг хүлээнэ¹⁰” гэсэн заалтуудаар “эрүүдэн шүүх” үйлдлээс урьдчилан сэргийлэх үүргийг Оролцогч улсуудад хүлээлгэсэн.

Нэмэлт протоколын 3 дугаар зүйлийн “Оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорих газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага /цаашид “үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага” гэнэ/ байгуулах, томилох, эсхүл хэвээр ажиллуулах үүрэг хүлээнэ¹¹” гэсэн заалтаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах үүргийг Оролцогч улсуудад хүлээлгэсэн.

Оролцогч улсууд өөрсдийнхөө нөхцөл байдалд тохируулан шинээр бие даасан хараат бус хөндлөнгийн байгууллага байгуулах, хүний эрхийн үндэсний байгууллага дээрээ түшиглэн хавсарсан хэлбэртэйгээр ажиллуулах, парламентын омбудсмены эрхлэх ажлын хүрээнд хавсарган гүйцэтгүүлэх, олон талт төлөөллийг оролцуулсан хэлбэртэйгээр байгуулсан байдаг.

Аль ч хэлбэрээр байгуулсан конвенцын дагуу үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын бүрэн эрхийг бүх хэлбэрээр хүлээн зөвшөөрч, хараат бус, бүрэн бие даасан байдлыг бэхжүүлэх үүргийг нэгдэн орсон улсууд шууд хүлээдэг.

Ийнхүү Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг үүсгэн байгуулах болон түүний бүрэн эрхийн талаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 3, 4, 17-23, 29 болон 35 дугаар зүйлд дэлгэрэнгүй заасан байна. Урьдчилан сэргийлэх байгууллагыг Нэмэлт протоколд заасан хэм хэмжээнд нийцүүлэн байгуулах нь Оролцогч улсын хүлээсэн үүрэг.

⁸ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц. 386 дахь тал.

⁹ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц. 391, 392 дахь тал.

¹⁰ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц. 393 дахь тал.

¹¹ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 415 дахь тал.

НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо нь Оролцогч улс урьдчилан сэргийлэх байгууллагыг Нэмэлт протоколд заасан хэм хэмжээнд нийцүүлэн байгуулсан эсэхийг тогтоодог.¹² Энэ чиг үүргийнхээ дагуу Дэд хороо нь нэгдүгээр тайлан илтгэлдээ урьдчилан сэргийлэх байгууллагыг байгуулах үйл явцын талаар зааварчилсан “Урьдчилсан удирдамж”-ийг нийтэлж, дараа дараагийн тайлангууддаа илүү өргөн цар хүрээг хамруулж, өөрийнхөө хуримтлуулсан туршлагад үндэслэн, урьдчилан сэргийлэх байгууллагыг үүсгэн байгуулах, түүнийг чиг үүргийг тодорхойлох, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгардаг хэд хэдэн асуудлуудыг тодорхой болгох зорилгоор Оролцогч улсуудын Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагуудад зориулсан удирдамжийг гаргажээ.

Уг удирдамж нь Урьдчилан сэргийлэх байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх “Суурь зарчмууд”, Оролцогч улсад чиглэсэн Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг үүсгэн байгуулахтай холбоотой болон урьдчилан сэргийлэх байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх асуудлуудыг хамарсан байна.

Энэхүү дүн шинжилгээний зорилго нь Оролцогч улс буюу Монгол Улс нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага /манай орны тухайд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгж”, цаашид “ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн” гэх/-ыг байгуулахдаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулах ХЭҮКтХ-ийн зорилт, хэм хэмжээг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын шаардлага болон НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны “Үндэсний Урьдчилан сэргийлэх байгууллагуудад зориулсан удирдамж” /цаашид “Дэд хорооны удирдамж” гэх/-д заасан суурь зарчмуудыг хангаж, нийцүүлсэн эсэхийг тодорхойлох, Монгол Улс олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэхэд хууль, эрх зүйн орчныг цаашид сайжруулан, нийцүүлэхэд оршино.

ХЭҮКтХ-ийн нийцэл, хэрэгжилтэд үнэлгээ хийснээр энэ хууль бодитой хэрэгжиж, зорилтоо хангаж байгаа эсэх, нийгэмд үйлдэгдэж байгаа эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадаж байгаа эсэх, цаашид Монгол Улсын олон улсын өмнө холбогдох конвенц, Нэмэлт протоколоор хүлээсэн эрүү шүүлтээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх үр нөлөөг сайжруулахын тулд хуулийг хэрхэн боловсронгуй болгох, эс бөгөөс тухайлсан хууль шинээр боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох юм.

¹² “Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагуудад зориулсан удирдамж. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс Урьдчилан сэргийлэх Дэд хороо. 12 дугаар хуралдаан. Женев хот, 2010 оны 11 сарын 15-19

1.2. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХҮРЭЭ

Хуулийн нийцэл, хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэлээ.

Аргачлалын 3.3.1-д заасны дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн нийцэл, хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх хүрээг дараах байдлаар тогтоов:

1. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол ба ХЭҮКтХ-ийн зорилт;
2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хараат бусын баталгаа;
3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүрэг, хамрах хүрээ;
4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны бүрэн эрхийн баталгаа;
5. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зөвлөмж;
6. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлан;
7. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн ба түүний нэгжийн бусад этгээдтэй харьцах харилцааны зохицуулалт ба хэлмэгдэхээс хамгаалах асуудал;
8. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хориглох зүйл зэрэг.

Үүнээс гадна дараах хуулиудын холбогдох зүйл, заалтууд нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколтой нийцэж буй байдлыг тодорхойлох зорилгоор үнэлгээ хийлээ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль;
- Гамшгаас хамгаалах тухай хууль;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
- Иргэний хууль;
- Коронивируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;
- Онц байдлын тухай хууль;
- Өршөөл үзүүлэх тухай хууль;
- Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль;
- Цагдаагийн албаны тухай хууль;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль;
- Шүүх шинжилгээний тухай хууль;
- Эрүүгийн хууль;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.

1.3. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу ХЭҮКтХ-ийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны зохицуулалт нь олон улсын конвенц, түүний Нэмэлт протоколтой нийцэж байгаа эсэхэд болон уг зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран “Зорилгод хүрсэн түвшин” болон “Практикт нийцэж байгаа байдал” гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт

Үнэлэх бүлэг	Хуулийн зүйл, заалт	Шалгуур үзүүлэлт
Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл (Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол ба ХЭҮК-ийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын нийцэл)	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1. заалт	Зорилгод хүрсэн түвшин
	5 дугаар зүйл. Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо 5.1. заалт	
	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.2. заалт	Зорилгод хүрсэн түвшин
	7 дугаар бүлэг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа	Практикт нийцэж байгаа байдал
	32 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн	Практикт нийцэж байгаа байдал
	19 дүгээр зүйл. Комиссын даргын бүрэн эрх 19.1.10 заалт	
	36 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж 36.1 заалт	
	36 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж 36.3 заалт	
	31 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа 31.2. заалт	
	39 дүгээр зүйл. Хууль зүйн баталгаа 39.3. заалт	

34 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх	Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал
31 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа 31.3. заалт	
38 дугаар зүйл. Эдийн засаг, нийгмийн баталгаа 38.1. заалт	
6 дугаар зүйл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 6.2. заалт	
33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүрэг	
33 дугаар зүйл. Тайлбар хэсэг	
34 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх 34.1.8. заалт	
8 дугаар бүлэг. Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн баталгаа 39.1. заалт	
35 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж	
31 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа 31.4. заалт	
7 дугаар бүлэг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа	
41 дүгээр зүйл. Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хориглох зүйл 41.1.2. заалт	



1.4. ҮНЭЛГЭЭНИЙ ХАРЬЦУУЛАХ ХЭЛБЭР

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн зорилт, хэм хэмжээ НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколтой нийцэж буй эсэх болон хэрэгжилтийн нөхцөл байдлыг Аргачлалын харьцуулах хэлбэрүүдээс “Байх ёстой болон одоо байгаа”, “Тохиолдол судлах” гэсэн хоёр хэлбэрийг сонголоо.

1.5. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА

Энэхүү дүн шинжилгээний ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл заалтын зорилгодоо хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, үйл ажиллагааны тайлан, илтгэлийг унших, судлах, харьцуулалт хийх, холбогдох албан хаагчидтай уулзаж ярилцлага хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлноос “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах”, “Холбогдох субъектээс судалгаа авах” аргыг хэрэгжүүлэв.

Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах хүрээнд: Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, эрүүдэн шүүхийн эсрэг Олон Улсын ном товхимол, гарын авлага, удирдамж, эмхэтгэл, өгүүлэл, судалгааны тайлан, илтгэлийг цуглуулж, үнэлгээ хийхэд ашигласан.

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд: Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколоор олгосон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн болон, түүний нэгжийн 6 албан хаагчидтай уулзаж, ярилцлага хийх аргаар судалгаа авсан. Мөн холбогдох байгууллагаас үйл ажиллагааны тайлан, судалгаа, дүн мэдээ мэдээллийг гаргуулан авч, үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргын дагуу хэрэгжилтийн үе шатыг хийж гүйцэтгэв. Ингэхдээ холбогдох байгууллагаас гаргуулсан баримт бичгийн судалгаа, албан хаагчидтай ганцаарчилсан ярилцлага хийх аргад тулгуурлаж энэхүү дүн шинжилгээний үнэлгээний ажлын хийж гүйцэтгэлээ.

2.1. БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА

ХЭҮКтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, журам, эрдэмтэн, судлаачдын бүтээл, илтгэл, судалгааны тайланг ашигласан болно:

Үндэсний хууль эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль;¹³
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль;¹⁴
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль;¹⁵
- Гамшгаас хамгаалах тухай хууль;¹⁶
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;¹⁷
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;¹⁸
- Иргэний хууль;¹⁹
- Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;²⁰
- Өршөөл үзүүлэх тухай хууль²¹;
- Онц байдлын тухай хууль;²²
- Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль;²³

¹³ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ (legalinfo.mn)

¹⁴ МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ (legalinfo.mn)

¹⁵ ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ (legalinfo.mn)

¹⁶ ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ (legalinfo.mn)

¹⁷ ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ (legalinfo.mn)

¹⁸ ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ (legalinfo.mn)

¹⁹ ИРГЭНИЙ ХУУЛЬ (legalinfo.mn)

²⁰ КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ (legalinfo.mn)

²¹ ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ (legalinfo.mn)

²² ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ (legalinfo.mn)

²³ СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ (legalinfo.mn)

- Төрийн албаны тухай хууль;²⁴
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль;²⁵
- Цагдаагийн албаны тухай хууль;²⁶
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль;²⁷
- Шүүх шинжилгээний тухай хууль;²⁸
- Эрүүгийн хууль;²⁹
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;³⁰

Олон улсын эрх зүйн акт

- НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц³¹;
- НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол³²;
- НҮБ-ын Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал³³;
- НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос Оролцогч улсын Урьдчилан сэргийлэх байгууллагад зориулсан удирдамж³⁴;

Олон улсын байгууллагын тайлан, зөвлөмж

- НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын тайлан, зөвлөмж
- НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Ажлын хэсгийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын тайлан, зөвлөмж

Судалгааны тайлан, эмхэтгэл

- Хүний эрхийн Олон улсын гэрээ ба Монгол Улс /Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын гэрээний хороод, хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс Монгол Улсад өгсөн зөвлөмжийн эмхэтгэл. 1971-2020/Хоёрдугаар боть. 2021 он, Улаанбаатар хот

²⁴ ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ (legalinfo.mn)

²⁵ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ (legalinfo.mn)

²⁶ ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ (legalinfo.mn)

²⁷ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ (legalinfo.mn)

²⁸ ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ (legalinfo.mn)

²⁹ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ (legalinfo.mn)

³⁰ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ (legalinfo.mn)

³¹ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц.

³² “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол

³³ “Хүний эрхийн олон улсын билл” Хүний эрхийн Түгээмэл тунхаглал

³⁴ docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=6QkG1d%2FPPRiCAqhKb7yhsquBIBCPFD%2BXL-NadyD9hiZ4SGqsp7QTjY12aNwfqi3CFkvYEqp%2BUSHT%2FCEAk5saRSeK0Q8FO nukz0hJM0206T%2FrtROW5qBoyJYZCbh7io7

- Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл /Тойм судалгаа/. О.Мөнхсайхан, Р.Очирбал. 2021 он, Улаанбаатар хот
- Бие даасан институтийн төсөв, санхүүгийн хараат бус байдалд хийх дүн шинжилгээ /Хүний эрхийн Үндэсний Комисс/ 2022 он. Улаанбаатар хот
- Хүний эрх. Онол, арга зүйн сэтгүүл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс. 2013 он.

Үйл ажиллагааны тайлан

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2022 оны тайлан. 2023 он. Улаанбаатар хот.

Ном, гарын авлага

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Гишүүн болон Нэгжид зориулсан гарын авлага. Нээлттэй нийгэм форум. Б.Хишигсайхан, ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер. Г.Агар-Эрдэнэ, Хуульч, судлаач. 2021 он. Улаанбаатар хот
- ХЭҮКтХ-ийн хэрэгжилтийн талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн болон түүнд туслах чиг үүрэг бүхий нэгжийн 6 албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийж, хуулийн зүйл, заалтын хэрэгжилтийн бодит байдал, хууль хэрэглээнд тулгамдаж буй асуудал, эерэг, сөрөг нөлөөллийг тодрууллаа.



ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛ БА ХЭҮКТХ-ИЙН ЗОРИЛТ

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. ХЭҮКТХ нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын зорилттой нийцэх зорилгодоо хүрсэн эсэх?

Конвенцын 16 дугаар зүйлд “Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ 1 дүгээр зүйлд тодорхойлсон эрүү шүүлтэд тооцогдохгүй төрийн албан тушаалтан буюу албаны үүрэг гүйцэтгэж буй бусад этгээд, тэдгээрийн өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр үйлдэгдэх хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх бусад үйлдлээс сэргийлэх үүрэг хүлээнэ³⁵” гэж заасан.

Нэмэлт протоколын 1 дүгээр зүйлд “Энэхүү Протоколын зорилго нь олон улсын болон үндэсний бие даасан байгууллага нь эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн хоригдож байгаа газарт эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтмол эргэж очих тогтолцоог бий болгоход оршино³⁶” гэж заасан.

Монгол Улсын ХЭҮКТХ-ийн зорилтыг 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж, Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж томьёолсон.

ХЭҮКТХ-ийн зорилт, Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколын зорилгыг харьцуулан авч үзвэл эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлээс сэргийлэх Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын зорилготой нийцэж байгаа боловч Нэмэлт протоколын “...тогтмол эргэж очих тогтолцоог бий болгох” гэж заасан зорилтыг агуулаагүй байна.

³⁵ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц. 385 дахь тал.

³⁶ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 414 дэх тал.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны одоогийн бүтэц оновчтой эсэх?

ХЭҮКтХ-ийн 2 дугаар бүлэгт Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо, түүний бүрэлдэхүүн, чиг үүрэг, бусад холбогдох харилцааг зохицуулсан.

Ингэхдээ 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, шүүх, прокурор, Үндсэн хуулийн цэц, төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комиссоос бүрдэнэ” гэж заажээ.

Хүн төрөлхтөн нийтээр хүлээн зөвшөөрсөн анхны баримт бичиг бол Хүний эрхийн түгээмэл тунхаглал юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталснаас хойш эрүүдэн шүүхийг олон улсад хориглосон. Тодруулбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй³⁷” гэж заасан байдаг. Энэ үүднээс “Эрүү шүүлтээс ангид байх эрх” нь хүний жам ёсны эрх бөгөөд ямар ч үед үл хязгаарлагдах, онцгой эрх юм.

Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь иргэн бүрийн жам ёсны болоод бусад эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, хоорондоо харилцан уялдаатай тогтолцоо.

Энэ тогтолцоонд хүний эрүү шүүлтээс ангид байх жам ёсны, ямар ч үед үл хязгаарлагдах, онцгой эрхийг хамгаалах, хангах зорилгоор урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эрхэлдэг тогтолцоо буюу Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг багтаагаагүй нь Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах тогтолцоо оновчтой бүрэлдээгүй болохыг харуулж байна.

Иймд ХЭҮКтХ-ийн 2 дугаар бүлгийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтад Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны бүрэлдэхүүнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн байхаар тусгах нь зүйтэй юм.

³⁷ ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ (legalinfo.mn)

3.2. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ХАРААТ БУСЫН БАТАЛГАА

Нэмэлт протоколын 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн:

- “Оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага, түүний ажилтан чиг үүргийнхээ хувьд хараат бус байх баталгааг хангана³⁸”,
- мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын шинжээчид шаардлагатай ур чадвар, мэргэжлийн мэдлэг эзэмшсэн байх явдлыг хангах арга хэмжээ авна³⁹”,
- 3 дахь хэсгийн “Оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, хөрөнгөөр хангах үүрэг хүлээнэ⁴⁰” гэсэн заалтуудаар түүнчлэн,
- Урьдчилан сэргийлэх байгууллага нь чиг үүргийнхээ хувьд хараат бус байх байдлыг баталгаажуулсан байна,
- Урьдчилан сэргийлэх байгууллагын гишүүдийг улируулан томилж болох ба тэдний бүрэн эрхийн хугацааг урьдчилан сэргийлэх байгууллагын чиг үүргийн хувьд хараат бус байх зарчимтай уялдуулан тогтооно,
- Урьдчилан сэргийлэх байгууллага нь Нэмэлт протоколд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд хараат бус байна,
- Оролцогч улс нь сонирхлын зөрчил гаргаж болохуйц хүнийг томилохгүй байж урьдчилан сэргийлэх байгууллагын бие даасан байдлыг хангана⁴¹ гэсэн Дэд хорооны удирдамжид тусгасан суурь зарчмуудаар Оролцогч улсууд ЭШУС үндэсний ажиллагааг байгуулахдаа хангаж, нийцүүлэх шаардлага, бие даасан, хараат бусын баталгааг тодорхойлсон.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагааг томъёолсон тодорхойлолт болон үндэсний ажиллагааг зохицуулсан 7 дугаар бүлэг нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын зарчимд нийцэх зорилгодоо хүрсэн эсэх?

Монгол Улс нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол болон Дэд хорооны удирдамжийн суурь зарчимд дурдсан “Урьдчилан сэргийлэх байгууллагын бүрэн эрхийг Үндсэн хууль, эсвэл бусад хуулиар тодорхойлон хуульчилсан байна” гэсэн заалтын дагуу ХЭҮКтХ-ийн 3 дугаар зүйл, хуулийн нэр томъёоны тодорхойлолтын 3.1.2 хэсэгт “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус,

³⁸ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 429 дэх тал.

³⁹ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 430 дахь тал.

⁴⁰ Мөн тал

⁴¹ docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=6QkG1d%2FFPPRiCAqhKb7yhssquBIBCPFD%2BXL-NadyD9hiZ4SGqsp7QTjY12aNwfqi3CFkvYEqp%2BUSHT%2FCEAk5saRSeK0Q8F0nukz0hJM0206T%2FrtROW5qBoyJYZCbh7io7

бие даасан, цогц үйл ажиллагаа (г)” гэж ЭШУС үндэсний ажиллагааг томьёолж, мөн хуулийн 7 дугаар бүлэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа”-г зохицуулснаар Нэмэлт протоколын 3 дугаар зүйлээр хүлээсэн үүрэг, Дэд хорооны удирдамжийн суурь зарчмын шаардлагад нийцүүлжээ.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. ХЭҮКтХ-ийн 32 дугаар зүйл нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

ЭШУС үндэсний ажиллагааны бүрэлдэхүүн ямар байх нь эрүү шүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэр үр дүнтэй байхад нөлөөлөх гол хүчин зүйл юм.

Урьдчилан сэргийлэх байгууллага нь бүрэн эрхээ зохистой хэрэгжүүлэх үүднээс Нэмэлт Нэмэлт протоколын 18 дугаар зүйлийн 1, 2 дахь заалтын шаардлагын дагуу Оролцогч улс нь үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын шинжээчид /Монгол Улсын тухайд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгжийн ажилтнууд/ шаардлагатай ур чадвар, мэргэжлийн мэдлэг, туршлага байдлыг харгалзан олон талын төлөөлөлтэй, тухайлбал, бүрэлдэхүүнд хууль зүйн болон эрүүл мэндийн мэргэшсэн ажилтнууд байх явдлыг заавал хангасан байх үүрэг хүлээсэн.

ХЭҮКтХ-ийн 32 дугаар зүйлийн зохицуулалтаас харахад “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр хууль зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай” байх шаардлагыг хангасан байх ёстой бол Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Хүний эрхийн Үндэсний Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг сонгон шалгаруулах журам”-д ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнийг сонгон шалгаруулахад:

- “хууль дээдлэх, шударга ёсыг баримтлах, аливаа нөлөөллөөс ангид, хараат бус байх, төвийг сахих, бодитой байх, ил тод байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх” зарчмуудыг баримтлан,
- “хууль зүйн дээд боловсролтой, эрх зүйч мэргэжлээр арваас доошгүй жил ажилласан, хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгээ мэргэжлийн үйл ажиллагаагаар нотлон харуулсан, хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр таваас доошгүй жил ажилласан” зэрэг өндөр шаардлагыг хангасан,
- “хууль зүйн чиглэлээр, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр, хүний эрхийг хамгаалах чиглэл”-ээр ажилласан туршлагатай хүнийг томилохоор зохицуулсан нь Нэмэлт протоколын 18 дугаар зүйлийн 2 дахь заалтын “шаардлагатай ур чадвар, мэргэжлийн мэдлэгтэй байх” шаардлагад нийцэж байна⁴².

⁴² Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Хүний эрхийн Үндэсний Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг сонгон шалгаруулах журам”-аас

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор Оролцогч улсууд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд 4 жил тутамд конвенцын хэрэгжилтийн талаарх тайланг хүргүүлэх үүрэгтэй. Монгол Улсын Засгийн газар ээлжит гурав дахь удаагийн тайлан⁴³гаа 2020 онд хүргүүлсэн ба түүнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд хамаарах хэрэгжилтийг тайлагнахдаа:

“148. ...Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох талаар тусгасан...,

150. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль батлагдсанаар Парисын зарчмуудын дагуу үйл ажиллагааг хараат бусаар, үр дүнтэй явуулах эрх хэмжээ бүхий хангалттай хүний нөөцөөр хангагдах эрх зүйн үндэслэл болсон...

155. Эрүү шүүлтийн эсрэг үндэсний механизмыг бий болгож, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хараат бус үйл ажиллагаа явуулах гишүүн, нэгжийн чиг үүргийг дээрх хуульд тусгасан. Тус нэгжид 1 удирдах ажилтан буюу комиссараас гадна гүйцэтгэх 7 албан хаагч, үйлчлэх 3 ажилтны орон тоог баталсан.” гэж тайланд тусгажээ.

Хэдий тийм боловч ХЭҮКтХ нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүний нөөцийн зохицуулалтыг ЭШЭК-ийн агуулгад нийцүүлээгүй байгаа нь анхаарал татаж байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. ХЭҮКтХ-ийн 19, 29, 36 дугаар зүйлийн зохицуулалт нь практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл тулгарч байгаа эсэх?

ХЭҮКтХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.10-т Комиссын даргын бүрэн эрхийг тусгахдаа “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх” гэж хуульчилсан нь хууль хэрэглээний үл ойлгогдох байдал үүсгэжээ.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнтэй хийсэн ярилцлагаас

...хууль хэрэглээний явцад тодорхойгүй зарим асуудлууд гарч ирж байна. ХЭҮКтХ-иар хараат бус байхаар хуульчилсан боловч хэрэгжилт дээрээ зарим зүйл дээр тийм биш байгаа нь үнэн. Монгол Улсын холбогдох хуульд төрийн байгууллага хоорондын харилцааг зохицуулсан. Харин байгууллагын дотоод нэгжээ дэмжихийг хуулиар зохицуулдаггүй. Гэтэл ийм зохицуулалтыг ХЭҮКтХ-д тусгасан нь өөрөө ХЭҮК болон ЭШУС үндэсний ажиллагаа хоёр нь тусдаа, бие даасан механизмууд гэсэн ойлголтыг бататгаад байгаа юм.

Монгол Улс нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 3 дугаар зүйлээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ одоо байгаа байгууллагад нэмэлт үүрэг, бүтэц үүсгэх хэлбэрээр буюу ХЭҮК-ын бүтцэд ХЭҮКтХ-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийг шинээр үүсгэж, түүнд туслах нэгжийг байгуулсан.

⁴³ Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс. Хоёрдугаар боть. 7.6 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг асуудал хариуцсан хороонд Монгол Улсаас конвенцын хэрэгжилтийн талаар хүргүүлэх ээлжит гурав дахь удаагийн тайлан /2020/ Хуудас 457-538

Ийнхүү байгуулагдсан ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгж нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасан нэршлийн дагуу Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа / механизм/ юм.

ХЭҮКтХ-ийн 29 дүгээр зүйлд “Комисс Тамгын газартай байх бөгөөд Тамгын газар нь Комиссын гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана”, “Тамгын газар нь Комиссын чиг үүргийг дагнан хэрэгжүүлэх газар, хэлтэстэй байх бөгөөд...” гэж 29.1 болон 29.2 дахь заалтуудад тусгаснаас үзэхэд ХЭҮК-ийн ажлын зохион байгуулалт нь “хэлтэс, тасаг” гэсэн бүтэцтэй байна.

ХЭҮК нь 7 хэлтэс, 1 тасгийн ажлын зохион байгуулалттайгаар Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг⁴⁴.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд туслах нэгж буюу ЭШУС үндэсний ажиллагааны ажилтнууд нь ХЭҮКтХ-ийн 36 дугаар зүйлийн 36.3-т зааснаар Комиссын Тамгын газарт харьяалагдаж, ХЭҮКтХ болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд заасан чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Уг нэгж нь Комиссын ажлын зохион байгуулалтын бүтцэд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтэс” гэж томъёологддог⁴⁵.

Комиссын Тамгын газар нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд үйл ажиллагаанд оролцох эрх зүйн зохицуулалтгүй байтал нэгжийн албан хаагчдыг харьяална гэсэн нь хараат бус байдалд нөлөөлөхүйц, хууль зүйн хувьд хоёрдмол агуулгатай зохицуулалт болсныг залруулж ЭШЭК, түүний нэмэлт протоколд нийцүүлэх шаардлагатай.

“Дэмжлэг үзүүлэх”⁴⁶ гэсэн ухагдахуун нь хоёр болон хэд хэдэн хуулийн этгээд, байгууллага хоорондын процессын харилцаанд үүсэх хамтын ажиллагааны хэлбэр юм.

ХЭҮКтХ-ийн 19.1.10 дахь заалт нь “Удирдлага нь” байгууллагынхаа нэг чиг үүргийг хэрэгжүүлж байгаа “дотоод дахь” бүтцээ дэмжиж ажиллахыг заасан буюу учир холбогдлын/логик шинж чанараа алдсан, хуулийн хэрэглээг хоёрдуулсан, үл ойлгогдох байдал үүсгэсэн, ач холбогдолгүй заалт болжээ.

⁴⁴ Хүний эрхийн Үндэсний Комисс (nhrcm.gov.mn)

⁴⁵ Бүтэц, зохион байгуулалт (nhrcm.gov.mn)

⁴⁶ дэмжих үйлийн нэр; тусламж, тусалцаа, тулгуур; *дэмжлэг үзүүлэх; Я.Цэвэлийн толь.

ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчтай хийсэн ярилцлагаас

...ХЭҮКХ-ийн холбогдох заалтууд практик дээр хэрхэн хэрэгжиж байгаа асуудал дээр зөвхөн нэг л жишээ дурдахад хангалттай болов уу. ЭШУС үндэсний ажиллагаа нь үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлах, мэдээлэх зорилгоор “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа” нэртэй цахим хуудсыг 2022 оны 10 дугаар сараас эхлэн хөтөлж байна. Гэвч шинэ тутамд байгуулагдсан механизм учраас илүү олон иргэнд эрүү шүүлтээс ангид байх эрхийнх нь тухай мэдлэг, ойлголтыг хүргэж, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа сурталчлах зорилгоор ХЭҮК-ын вэб хуудаст мэдээллээ байршуулж байх талаар Комиссын холбогдох албан тушаалтанд удаа дараа хандсан боловч өнөөдрийг хүртэл /2024 оны 01 дүгээр сар/ хоёр жилийн хугацаанд энэ асуудал шийдэгдээгүй л байна. Вэб хуудсанд хандаж мэдээллээ оруулах эрхийг шалтгаангүй, урьдчилан мэдэгдэлгүй хааж, танайх фэйсбүүк хуудас нээж тэрэндээ л мэдээллээ оруулж бай гэх зэргээр хараат бус үндэсний ажиллагаанд хөндлөнгөөс оролцож байдаг нь үнэхээр бэрхшээлтэй..

“Хуулийн хэрэглээг хоёрдуулсан” гэх нөхцөлийг тодруулах нь зүйтэй.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааг дэмжих бүрэн эрхийг Комиссын даргад олгосон уг заалтын агуулга нь “учир холбогдлын шинж чанараа алдаагүй”, “бүрэн төгс ойлгогдохуйц” гэж үзвэл ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний нэгэн адил тусгайлсан чиг үүргийг дагнан хэрэгжүүлдэг бусад хоёр гишүүн болох Хүний хувийн мэдээллийн аюулгүй байдал эрхэлсэн гишүүн, Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай заалт уг хуульд агуулагдах ёстой болж байна.

Өөрөөр хэлбэл, ХЭҮК-ын Комиссын дарга нь бусад гишүүдийнхээ үйл ажиллагааг “дэмжиж ажиллах”-ыг мөн адил хуульчлах учиртай. Гэвч ХЭҮКХТ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.10 заалтад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай тусгажээ.

Энэ хамаарлыг харахад, Монгол Улс нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 3 дугаар зүйлд заасан “урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага”-ыг 18 дугаар зүйлийн 1 дэх заалтын “хараат бус байх баталгаа”-г хангаж байгуулсан болохыг ХЭҮКХТ-ийн уг заалт баталж байна гэж дүгнэхээр байна.

“Хуулийн хэрэглээг хоёрдуулсан” гэх нөхцөлийн нэг тал нь энэ юм. Хялбарчилбал, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь чиг үүргээ ХЭҮК-ийн үйл ажиллагаанаас хараат бусаар хэрэгжүүлдэг гэсэн ойлголтыг уг заалт илэрхийлж байна.

Нөгөө талаас, хэрэв ХЭҮКХТ нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгжийн ХЭҮК-ийн үйл ажиллагаанаас хараат бус, бие даасан байдлыг 19.1.10 дахь заалтаар хангасан гэж үзвэл Нэмэлт протоколын 4 дүгээр хэсэг, Дэд хорооны удирдамжийн суурь зарчимд тусгасан “Үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах нөөцтэй байх⁴⁷” гэсэн баталгааг ч мөн хангасан байх ёстой.

Хэдий тийм боловч уг хууль нь олон зүйл заалтаар Нэмэлт протокол, Дэд хорооны удирдамж тодорхойлсон хараат бусын зарчмыг зөрчсөн болохыг дараах хэсгүүдэд шинжиллээ.

⁴⁷ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 429 дэх тал

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. ХЭҮКтХ-ийн 31, 39, 36 дугаар зүйлийн зохицуулалт нь практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Нэмэлт протоколын 3 дугаар зүйлд заасан “үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага” болохынхоо тухайд 18 дугаар зүйлд тусгасан зарчим болон, Дэд хорооны удирдамжид тусгасан “Урьдчилан сэргийлэх байгууллага нь чиг үүргийнхээ хувьд хараат бус байх байдлыг баталгаажуулсан байна”, “Урьдчилан сэргийлэх байгууллагын гишүүдийг улируулан томилж болох ба тэдний бүрэн эрхийн хугацааг урьдчилан сэргийлэх байгууллагын чиг үүргийн хувьд хараат бус байх зарчимтай уялдуулан тогтооно⁴⁸” гэсэн хараат бус байх суурь зарчмуудад нийцсэн байх учиртай.

ХЭҮКтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.2 хэсэгт:

- “Комиссын гишүүн болон бусад албан тушаалтан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглоно”,
- 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт “Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх чиглэлээр захидал харилцааны мэдээллийг задруулахыг хориглоно” хэмээн хуульчилсан нь Нэмэлт протоколын 18 дугаар зүйлийн 1, -ийн “хараат бус байх” зарчимд нийцэж байгаа боловч
- 36 дугаар зүйлийн 36.1 хэсгийн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллана”,
- 36 дугаар зүйлийн 36.3 хэсгийн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж нь Комиссын Тамгын газарт харьяалагдах ... ” гэсэн заалтуудаар ЭШУС үндэсний ажиллагааны хараат бус байдлын баталгааг бүрэн хангаагүй байна.

ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчтай хийсэн ярилцлагаас

...ЭШУС үндэсний ажиллагаа нь Нэмэлт протокол болон ХЭҮКтХ-ийн заалтаар “бие даасан, хараат бус”-аар үйл ажиллагаагаа явуулах ёстой боловч амьдрал дээр энэ заалтууд хэрэгждэггүй. ХЭҮКтХ-д ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь өөрт нь туслах нэгжийн дотоод зохион байгуулалтыг шийдэх эрхтэй. Гэтэл ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний шийдвэрлэж, зохицуулалт хийсэн дотоод зохион байгуулалтын асуудлыг ХЭҮК-ын зүгээс хүлээн зөвшөөрдөггүй, үүнээс үүдэж албан хаагчид бидэнд өдөр тутмын үйл ажиллагаагаа саадгүй явуулахад төвөгтэй асуудал үүсдэг. ЭШУС хэлтсийн албан хаагчид зөвхөн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд туслах чиг үүргийг хүлээнэ, гишүүн нь тэдгээр албан хаагчдын харьяалагдах хэлтсийн дотоод зохион байгуулалтыг шийдэх эрхтэй гэж хуульчилсан атал бодит байдал дээр хуулийн энэ зохицуулалтыг комиссын зарим албан тушаалтнууд хүндэтгэхгүй, сахихгүй байдал нь Үндэсний ажиллагааны албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна.

⁴⁸ Microsoft Word - CAT.OP.12.6.DOC (un.org)

Хэдийгээр ХЭҮКтХ нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд Комиссын гишүүд, албан хаагчид хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглохыг 31.2 дахь заалтаар хуульчилсан боловч ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд туслах нэгжийн ажилтнуудыг Тамгын газрын ажлын зохион байгуулалтад хамруулж, улмаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр баталсан А/17 дугаартай “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.2 заалт⁴⁹-аар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн даргыг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, нэгжийн ажилтнуудыг Тамгын газрын даргын тушаалаар томилохоор зохицуулсан нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд “хөндлөнгийн нөлөөлөл, оролцоо”-оос ангид байхыг хангасан 31.2 дахь заалтаа үгүйсгэсэн байна.

ХЭҮКтХ-ийн 31.2 дахь заалт ийнхүү ХЭҮК-ын Тамгын газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-аар үгүйсгэгдсэнээр нэгжийн хүний нөөцийг бүрдүүлэх, сонгох асуудалд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх, ЭШУС үндэсний ажиллагааны хараат бус байдлын баталгаа зөрчигджээ.

Энэ тухай анхааруулга, зөвлөмжийг НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг 2022 оны 10 дугаар сарын 03-аас 14-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийгээд Засгийн газарт хандаж гаргасан зөвлөмждөө дурдсаныг иш татваас:

“18.Мөн тус нэгжийн боловсон хүчнийг сонгон шалгаруулахад Төрийн албаны зөвлөл ямар үүрэг гүйцэтгэж байгаа, асуудал эрхэлсэн Гишүүн сонгон шалгаруулалтад хамгийн бага үүрэг гүйцэтгэдэг байдалд Ажлын хэсэг санаа зовж байна. Ажлын хэсэг тус механизмын бие даан ажиллах чадамжийн чухлыг онцолж, боловсон хүчнийг сонгохдоо бие даасан байдлыг нь хангахыг Засгийн газарт анхааруулж байна. Мөн Монгол Улсын газар зүйн байршил, зарим хорих ангиуд маш алслагдсан бүс нутагт оршдог тул тус нэгж аль болох түргэн хугацаанд 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж эхлэх нь чухал юм” гэж анхааруулаад,

“88 (b) Боловсон хүчнийг сонгох асуудалд Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын бие даасан байдлыг хангах; Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын нэгжийг 10 хүний бүрэлдэхүүнтэй болгож, чиг үүргийг нь хангалттай нөөцийн хуваарилалттайгаар аль болох хурдан эхлүүлэх;⁵⁰ зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газарт өгчээ.

⁴⁹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр баталсан А/17 дугаартай “Хөдөлмөрийн дотоод журам”

⁵⁰ g2312921.pdf (un.org)

ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчаас авсан ярилцлагаас

...Өнгөрсөн хугацаанд бид цөөн албан хаагч, бага зардлаар нэлээдгүй ажлыг амжуулж чадсан. Тухайлбал, бид 2023 онд нийт зургаан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асрамжийн газарт хяналт шинжилгээ хийж ажилласан. Уг хяналт шинжилгээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд тогтоогдсон нөхцөл байдлууд, тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, цаашид эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжийг салбарын сайдад хүргүүлсэн. Уг Зөвлөмжийн биелэлтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"⁵¹-ын 6 дугаар зүйлд заасны дагуу үнэлэн, 65,7 хувийн биелэлттэй гэж тооцож, тухайн байгууллагад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх, урьдчилан сэргийлэх нөхцөл боломж бодитойгоор бий болох үр дүнд хүрсэн гэж дүгнэсэн.

ЭШУС үндэсний ажиллагааг бие даасан байдлыг бүрэн хангаж, хүний нөөцийг газар нутгийн тархмал байдал, хяналт шинжилгээний давтамжийн тоо зэрэг хүчин зүйлүүдтэй уялдуулан бүрэлдүүлснээр Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, конвенц, холбогдох бусад хуулиар баталгаажуулсан эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа илүү хүчирхэг, өргөн далайцтай явагдаж, илүү их үр дүнд хүрэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. ХЭҮКтХ-ийн 34 дүгээр зүйлийн зохицуулалт нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын ЭШУС үндэсний ажиллагааны хараат бус байх баталгааг хангах шаардлагад нийцсэн эсэх?

ХЭҮКтХ-ын 36.3 дахь заалт нь нэгжийн дарга, ажилтан төрийн захиргааны ажилтан байхаар зохицуулсан. Нөгөөтэйгөөр төрийн захиргааны ажилтныг томилох эрх бүхий албан тушаалтныг уг хуульд нэрлээгүй байна.

⁵¹ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6 дугаар зүйлийн 6.3. дахь хэсэг

- 6.3.1. "бүрэн хэрэгжсэн"-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);
- 6.3.2. "хэрэгжих шатанд"-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-90 хүртэл хувь); (Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)
- 6.3.3. "хэрэгжилт хангалтгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-50 хүртэл хувь); (Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)
- 6.3.4. "хэрэгжээгүй"-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-10 хүртэл хувь);
- 6.3.5. "хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй".

ХЭҮКтХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.9, 34.1.10, 34.1.11 дэх заалтууд нь “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн даргыг томилох, чөлөөлөх”, “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх”, “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам баталж мөрдүүлэх” бүрэн эрхүүдийг ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд олгожээ.

ХЭҮКтХ-д төрийн захиргааны ажилтныг томилох эрх бүхий албан тушаалтныг нэрлээгүй, мөн 34.1.9, 34.1.10, 34.1.11 дэх заалтуудаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд бүрэн эрх олгосон байгаа нь түүнд туслах нэгжийн албан хаагчийг томилох эрх зүйн байдлыг өөрт нь бүрдүүлсэн гэж дүгнэгдэнэ.

Иймд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хуулиар олгогдсон бүрэн эрхэд түүнд туслах нэгжийн албан хаагчийг сонгох, томилох эрхийг олгосноор Нэмэлт протоколын “хараат бусын баталгаа⁵²”-г хангах шаардлагад ХЭҮКтХ-ийг нийцүүлэх нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 6. ХЭҮКтХ-ийн 31, 38, 6 дугаар зүйл нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

ЭШУС үндэсний ажиллагааны өөр нэгэн чухал баталгаа нь санхүүгийн хараат бус байдал юм. Урьдчилан сэргийлэх байгууллага нь Нэмэлт протоколд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд хараат бус байна гэсэн суурь зарчмыг Дэд хорооны удирдамжид дурдсан байна.

НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад 2017 онд хийсэн айлчлалынхаа дагуу Засгийн газарт хандаж гаргасан зөвлөмждөө:

“Үндэсний урьдчилан сэргийлэх механизм үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад шаардагдах нөөцөөр хангагдахыг зөвшөөрөх ёстой. Нэмэлт протоколын дагуу чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулж санхүүгийн болон үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлаар бүрэн хангагдах шаардлагатай. Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад, бусад байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг гаргахад нөөцийг жилийн төсөвт тусгайлан нэг нэгж болгон оруулж, урьдчилан тооцоолох замаар баталгаажуулна.” гэж тусгажээ.

“ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд өөрийн үйл ажиллагаанд зориулагдсан санхүүжилтийг бие даан хуваарилах боломжийг олгох замаар Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын санхүүгийн бие даасан байдлыг хангах” тухай зөвлөмжийг НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг Монгол Улсад өгсөн.

НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын Газраас гаргасан Төсвийн хяналт дахь хүний эрх, дүн шинжилгээ ба зөвлөгөө сургалтын удирдамжид хүний эрхийг хангах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа төсвөөс хамаарахын чухлыг тодорхойлохдоо:

⁵² “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 429 дэх тал.

“Бүх эрх төсвөөс хамаарч болно. Энэ утгаараа хүний ямар эрхүүд хэрэгжиж, хэнд зориулагдаж байгаа гэдэгтэй улсын төсөв шууд холбогддог. Төсөвт шинжилгээ хийх нь бодлого ба үйл ажиллагаа хоорондын зөрүүг хянах, хүний эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх явдлыг хангах, бодлогын өөр сонголт ба эрэмбийг дэмжих, эцэст нь хариуцлага хүлээгчдийн үүргээ биелүүлэх хариуцлагыг бэхжүүлэх чухал хэрэгсэл юм. Хүний эрхүүдийг үндэс болгон төсөвт хандах нь ил тод, хариуцлагатай, алагчлалгүй, оролцоонд тулгуурласан бодлогын сонголт хийхийг шаарддаг. Эдгээр зарчмуудыг төсвийн төсөл боловсруулах үе шатаас эхлээд төсвийн үйл ажиллагааны бүх шатанд хэрэгжүүлэх ёстой. Төсвийн төсөл боловсруулах үе шат нь парламентаар батлагддаг үндэсний хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаатай байх шаардлагатай бөгөөд парламент нь эргээд санал, хэрэгжилт, хяналтыг сайтар үнэлж, зохих өөрчлөлт оруулах эрх мэдэл, цаг хугацаатай байх ёстой⁵³” хэмээжээ.

ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагчтай хийсэн ярилцлагаас

...Одоогийн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хуулиудын зохицуулалтаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь үйл ажиллагаандаа зориулагдсан төсвийг захиран зарцуулах боломжгүй болж, үндэсний ажиллагааны санхүүгийн хараат бус байдал хангагдах нөхцөл бүрдээгүй гэж үзэж байна. Тухайлбал, хяналт шинжилгээ хийхэд холбогдох төсөв, томилолтын зардлыг Комиссын Тамгын газарт зайлшгүй танилцуулж, баталгаажуулдаг тул бидний гэнэтийн байдлаар хийхээр зорьж байгаа хяналт шинжилгээний маршрутын талаарх мэдээлэл түгэн тархах зэрэг саад тулгардаг. Мөн шөнийн цагаар ч, мөргөлдөөн, үймээн самууны үед ч, байгалийн гамшгийн үед ч ялгаагүй хүний эрх чөлөөг хассан газруудад гэнэтийн хяналт шинжилгээ хийх шаардлагатай. Санхүүгийн болон техник хэрэгслийн хувьд хараат бус, бие даасан байдал хангагдсан үед л бид хүссэн цагтаа, хэнд ч мэдээллээ алдалгүйгээр Нэмэлт протоколын шаардлагыг бүрэн хангаж хяналт шинжилгээгээ хийнэ. Тэгж байж тогтолцоонд нуугдсан нөхцөл байдлыг илрүүлнэ.

ХЭҮКтХ-д зааснаар ХЭҮК болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь хэн алинаасаа хараат бус, бие даасан хоёр институт байхаар хуульчлагдсан. Энэ ч үүднээс ЭШУС үндэсний ажиллагааны санхүүжилт ХЭҮК-ын төсвөөс тусдаа байх үндэслэл гарч ирнэ.

ХЭҮКтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.3-т “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна”, 38 дугаар зүйлийн 38.1-д “Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана” гэж заасан нь ЭШУС үндэсний ажиллагааны төсөв ХЭҮК-ийн төсвөөс тусдаа байхыг илэрхийлсэн заалт юм.

Хэдий тийм боловч мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 хэсэгт “Комиссын төсөв үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэх, шинжээч томилох ажиллуулахад шаардагдах зардал

⁵³ Төсвийн хяналт дахь хүний эрх, дүн шинжилгээ ба зөвлөгөө, сургалтын удирдамж, Женев, ХЭДКГ, 2010.

болон бусад зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдана” гэж зааснаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны төсвийг ХЭҮК-ын төсөвт хамаатуулж тусгажээ.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтын дагуу ХЭҮК-ын Төсвийн шууд захирагчийг тодорхойлох боломжгүй. Комиссын даргын тушаалаар томилохоор эрх зүйн зохицуулалттай байна.

ХЭҮКтХ-д зааснаар ХЭҮК болон ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь бие даасан хоёр институт байхаар хуульчлагдсан ч санхүү, төсвийн хувьд нэгдмэл, комиссын төсвөөс үндэсний урьдчилан сэргийлэх ажиллагааны төсвийг ялган байршуулаагүй байна. Иймээс санхүүгийн гүйлгээ хийхэд нэг болон хоёрдугаар гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтнууд нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх зэрэг нөхцөл байдал үүсгэх эрсдэлийг үүсгэсэн байна.

Энэ нь өргөн утгаараа Монгол Улс нэгдэн орсон гэрээгээ бүрэн биелүүлээгүй гэж дүгнэж болох бөгөөд, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд төсөв хувиарлаагүй, түүний сангийн яаман дахь данс нь өнөөдрийг хүртэл хоосон байгаа нь цаашид эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрхийн хамгаалал эрсдэлт нөхцөлд байгааг олон улсын шинжээч нар дүгнэлтдээ дурджээ.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнтэй хийсэн ярилцлагаас

...НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлд илгээсэн өмнөх тайландаа Монгол Улсын Засгийн газар ЭШУС үндэсний ажиллагааны хүний нөөц, төсөв хөрөнгийг шийдэж, байгуулсан гэж танилцуулсан. Гэтэл бодит байдал өөр дүр зураглалтай байгаа нь харамсалтай. НҮБ-ын ЭШУС Дэд хороо 2024 онд манай улсад албан ёсны хоёр дахь айлчлалаа хийх гэж байна. Энэ айлчлалын мөрөөр манай Засгийн газарт өгөх зөвлөмж ямар байх нь ойлгомжтой. НҮБ-ын гэрээний хороод нэг л агуулга бүхий зөвлөмжийг удаа дараа өгч байгаад манай төр, засаг дүгнэлт хийж, дорвитой арга хэмжээ авах цаг хугацаа нь болсон гэж би үзэж байна. Гэхдээ гол асуудал нь ХЭҮК-ын удирдлагын зүгээс шийдвэрлэж болох асуудлыг хуулийн хүрээнд анхнаасаа зөв өнцгөөс харж, олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжид заасан хүний эрхийн хамгааллын шинэ механизмыг дэмжих үүргээ шударгаар биелүүлсэн бол бид өнөөдөр илүү бэхэжсэн, тулгараад буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэсэн байх боломжтой байсан гэж харж байна. Өнөөдөр ХЭҮК-ын удирдлагын зүгээс ЭШУСҮА-ны бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч, дэмжин бэхжүүлэх талаар тодорхой санал санаачилга гаргахгүй байгаад үнэхээр харамсдаг. Комиссын удирдлагыг үүргээ хангалтгүй биелүүлж байгаа талаар олон нийтийн шүүмж өрнөж, УИХ-аас түүнийг өөрчилж, дараагийн даргыг томилсон нь түүний баримталж ирсэн бодлого алдаатай байсны нотолгоо юм. Комиссын даргыг үндэсний механизмыг хариуцсан гишүүнийг дэмжих үүргийг хуульчилсан нь анхнаасаа буруу бөгөөд бүх талаар харилцан бие биеэсээ хараат бус байх гол зарчмыг баримтлах эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

“Нээлттэй нийгэм форум” Төрийн бус байгууллагын ЭШУС үндэсний ажиллагааны төсвийн хараат бус байдалд хийсэн “Бие даасан институтийн төсөв, санхүүгийн хараат бус байдалд хийх дүн шинжилгээ” судалгааны тайлан⁵⁴гаас энд хэсэгчлэн авав:

⁵⁴ Бие даасан институтийн төсөв, санхүүгийн хараат бус байдалд хийх дүн шинжилгээ. Нээлттэй нийгэм форум. 2022 оны 12 дугаар сарын 10. Улаанбаатар хот.

2.1. ХЭҮК-ын төсвийн захирагч нарт олгогдсон эрх хэмжээг шинжилбэл:

Төсвийн байгууллагын⁵⁵ төсвийн харилцааг зөвхөн Төсвийн тухай хуулиар зохицуулдаг⁵⁶. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга тухайн байгууллагын” төсвийн ерөнхийлөн захирагч байхаар заасан тул ХЭҮК-ын дарга нь тухайн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч болно. Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ... Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” гэж заасан тул жил бүрийн төсөв нь ерөнхийлөн захирагчтай шууд хамааралтай байдаг.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж, 14.5 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч нь түүнд хамаарах төсвийн асуудлыг хариуцан гүйцэтгэх санхүүгийн нэгж, нягтлан бодогч, ажилтантай байна” гэж тус тус зохицуулсан. Үүний дагуу ХЭҮК-ын дарга нь төсвийн ерөнхийлөн захирагч болохын хувьд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын төсвийн шууд захирагчийг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч тогтооно” гэж, 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн” шууд захирагч байх зохицуулалтыг баримтлан ХЭҮК-ын Тамгын газрын дарга нь тухайн байгууллагын төсвийн шууд захирагч болно.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалтаар төсвийн шууд захирагч нь төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах бүрэн эрхийг хэрэгжүүлж, мөн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт зааснаар үр дүнгийн гэрээний дагуу төсвийн зарцуулалт, бүрдүүлэлтийн талаар харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө хариуцлага хүлээдэг.

Нэгэнт ҮУСБ-ыг ХЭҮК-ын дэргэд байгуулахдаа үйл ажиллагаа нь хараат бусаар байгуулсан ч Төсвийн тухай хуульд зааснаар төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахад Төсвийн тухай хуульд заасан төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагч, ерөнхий болон ахлах нягтлан бодогч нарын хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийг өөрчлөх боломжгүй юм. Мөн ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнийг төсвийн шууд захирагч болгох боломжгүй буюу төсвийн шууд захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө ажлаа хариуцаж, үүрэг хүлээдэг тул хараат бусаар үйл ажиллагаа явуулах бүрэн эрхийг зөрчихөөр байна.

⁵⁵ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т “төсвийн байгууллага” гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүргүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг ойлгохоор хуульчилсан байдаг.

⁵⁶ Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг.

ЭШЭК, түүний нэмэлт протоколын оролцогч улсууд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг үр дүнтэй, бие даасан байдлаар ажиллуулах, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын дагуу чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийн хуваарилалтыг хуулийн зохицуулалтаар хийх үүрэгтэй. Санхүүгийн бие даасан байдал нь бие даасан байдлын үндсэн, урьдчилсан нөхцөл юм. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг байгуулах тухай хууль тогтоомжид тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр, мөн чанарын тухай заалтуудыг тусгаж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд жил бүрийн санхүүжилт олгох үйл явцыг тодорхой зааж өгөх ёстой.

Төсвийн хуваарилалтын үе шатууд дараах байдалтай байж болно.

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь өөрийн ажлын төлөвлөгөөний дагуу жилийн төсвөө гаргах.
2. Хэрэв ХЭҮБ-ын дэргэд байгуулагдсан бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсвийг уг байгууллагаас тусад нь боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх ёстой.
3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны дарга/гишүүн УИХ-д төсвөө танилцуулах.
4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь нийт хуваарилсан төсвийн хүрээнд зардлын тэргүүлэх чиглэлээ өөрсдөө тодорхойлох эрхтэй.⁵⁷

Тиймээс төсвийн ерөнхийлөн захирагчаар ЭШУСАЭГ-ийг шууд томилох нь тулгараад буй бэрхшээл, цаашид үүсэх эрсдэлийг бий болгохгүй, гэрээний үүргийг бүрэн биелүүлэх хамгийн зөв шийдвэр гэж дүгнэж болно.

2.2.ХЭҮК-ын 2023 оны төсвийн санал, төсвийн хэмжээг дүгнэвэл:

ХЭҮК-ын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 02/601 дугаартай албан бичгээр ХЭҮК-ын 2023 оны урсгал зардлыг 7,156.2 сая төгрөгөөр тооцоолж, төсвийн санал гаргасан. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн УИХ-13/7378 дугаартай албан бичгээр дээрх төсвийг хянан 2,596.0 сая төгрөгөөр багасгаж, 4,560.2 сая төгрөгөөр зөвшөөрсөн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалтын дагуу Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн хязгаарыг батлах тухай” 258 дугаар тогтоолын хавсралтын XXVI-д ХЭҮК-ын даргын 2023 оны төсвийн урсгал зардал 2,597.9 сая төгрөг, хөрөнгийн зардал 142.0 сая төгрөг, нийт 2,739.9 сая төгрөгийн суурь зарлагын дүнтэй байхаар тооцоолсон байдаг.

⁵⁷ NPM_Guide_EN.pdf (ohchr.org)

Харин Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д зааснаар ХЭҮК-ын даргын зардлыг 4,480.5 сая төгрөгөөр баталж, анхны төсвийн саналыг 37 хувиар буюу 2,675.7 сая төгрөгөөр багасгаж баталсан байна. Ийнхүү багасгаж төсөвлөхдөө ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний төсөвт өөрчлөлт оруулсан эсэх нь нийтэд ил тод биш байна. Хэрэв ҮУСБ-ын төсвийн саналыг төсвийн төсөл боловсруулагч, эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас багасгаж төсөвлөсөн бол Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт заасан зохицуулалттай зөрчилдөхөд хүргэнэ.

Хэдийгээр Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 31.3 дахь хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.” гэж заасан боловч Төсвийн тухай хуульд асуудал эрхэлсэн гишүүний төсвийн ерөнхийлөн захирагч байх бүрэн эрхийн талаар нэмэлт оруулалгүй орхигдуулснаар төсвийн хараат бус байх байдлыг ХЭҮК-оос хараат мэтээр хоёрдмол утга үүсгэж, эрх зүйн хувьд тодорхойгүй байдал үүсгэжээ.

2.3. Гадаадын зээл, тусламж, хандивын хөрөнгийг захиран зарцуулахад анхаарах асуудал

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-д заасан “зээл, тусламжийн санхүүжилт, зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын удирдлагыг хэрэгжүүлэх, үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх” бүрэн эрхийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлдэг. Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.7-д зааснаар гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн биелэлтийг төсвийн удирдлагаар хангаж ажиллах бүрэн эрхийг төсвийн ерөнхийлөн захирагчид олгосон байдаг.

Мөн төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байдаг нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмын хэрэгжилт болдог.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн зохих журмын дагуу Тусгай санг байгуулна. Энэ санг Нэгдсэн Үндэстний Байгууллагын санхүүгийн дүрэм, журмын дагуу захиран зарцуулж, Урьдчилан сэргийлэх дэд хороо оролцогч улсад очсоны дараа гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх, үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг дэмжих, сургалтын хөтөлбөрт санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зарцуулна” гэж заасан.

Тус зохицуулалтын хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн хандив, тусламж авахад дараах хүндрэлтэй нөхцөл байдлууд үүснэ. Тухайлбал, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт зааснаар хуульд өөрөөр заагаагүй бол “эмнэлгийн үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, соёлын үйлчилгээ болон хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх”-д хандив, тусламж авч болохоор хязгаарлагдмал зохицуулалт үйлчилдэг. Мөн зүйлийн 25.12 дахь хэсэгт



“Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тусламжийн орлогыг төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулна” гэж заасан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-д зааснаар Төрийн сангийн нэгдсэн санд тухайн орлого байршдаг нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн үйлчлэлтэй шууд хамааралтай бөгөөд журамд зааснаар хандив, тусламжийн төрөл, хэлбэрээс хамаарч нийтлэг, тусгай шаардлага тавигддаг болно.

Иймд хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын болон дотоод төрийн өмчит бус хуулийн этгээдээс оруулах тусламж, хандивын орлогыг гагцхүү Төрийн сангийн нэгдсэн сангаар дамжуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн батлагдсан төсвийн 50 хувиас хэтрэхгүй байх зэрэг журамд заасан шаардлагуудыг хангах эрх зүйн шаардлагатай. Мөн тухайн хандив, тусламжийн орлогыг захиран зарцуулахад төрийн сангийн үйл ажиллагааны журам үйлчлэх тул ХЭҮК болон ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний харилцан уялдаатай төсөвлөлт, төлөвлөгөө болон зарцуулалтын хэлбэр, төрлийг нарийвчлан тогтоох шаардлага үүсэхээр байна.”

Хэдийгээр ХЭҮКтХ-ийн 31.3; 38.1 дэх хэсгийн зохицуулалтууд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны эдийн засгийн баталгааг хангасан боловч, “Нээлттэй нийгэм форум” Төрийн бус байгууллагын дээрх судалгааны дүнд тогтоогдсон Монгол Улсын Төсвийн тухай хуулиар зохицуулагдаж буй төсвийн байгууллагын төсвийн харилцаа, Гадаадын зээл, тусламж, хандивын хөрөнгийг захиран зарцуулалтын харилцаа болон ХЭҮКтХ-д ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь бие даасан төсөвтэй байх талаар зохицуулалтыг агуулаагүй зэрэг баримтууд нь Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны санхүүгийн хувьд хараат бус байх баталгааг хангах үүрэг хууль, эрх зүйн орчны оновчтой бус зохицуулалтын улмаас хангалтгүй хэрэгжиж байгааг илтгэж байна.

3.3. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ, ХАМРАХ ХҮРЭЭ

Нэмэлт протоколын 19 дүгээр зүйлийн:

(а) “4 дүгээр зүйлд заасан хорих газарт эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхээс хамгаалах явдлыг шаардлагатай тохиолдолд бэхжүүлэх зорилгоор эдгээр хүнтэй хэрхэн харьцаж байгаа байдлыг тогтмол шалгах”,

(b) “Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох хэм хэмжээг харгалзан эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй харьцах, тэдний байгаа нөхцөлийг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагад зөвлөмж өгөх ба эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх”,

(c) “Мөрдөж байгаа хууль болон боловсруулж байгаа хуулийн төсөлд санал, дүгнэлт өгөх” гэсэн заалтуудаар Оролцогч улсуудын ЭШУС үндэсний ажиллагааны чиг үүргийг тодорхойлоод,

4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү протоколд заасны дагуу оролцогч улс бүр төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу, эсхүл түүний санаачилгаар, эсхүл түүний идэвхтэй буюу идэвхгүй зөвшөөрлөөр хүний эрх чөлөөг хассан эсхүл хассан байж болзошгүй өөрийн харьяа болон хяналтад байдаг нутаг дэвсгэрт хамаарах аль ч газар (цаашид “хорих газар” гэнэ)-т энэхүү протоколын 2 ба 3 дугаар зүйлд заасан байгууллагууд очихыг зөвшөөрөх үүрэгтэй...”⁵⁸ гэж чиг үүргийн хамрах хүрээг тогтоосон.

Харин 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтаар “Энэхүү протоколын зорилгод “эрх чөлөөгөө хасуулах” гэж хүнийг шүүхийн, захиргааны эсхүл эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тухайн хүн өөрийн хүслээр орхин явах боломжгүй цагдан хорих, хорих эсхүл харуул хамгаалалт бүхий нийтийн буюу хувийн газарт байлгахыг хэлнэ”⁵⁹ хэмээн хамрах хүрээний шинж чанарыг тодорхойлсон.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйл нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын “бүх газар” гэсэн тодорхойлолтод нийцүүлэн ЭШУС үндэсний ажиллагааны хяналт шинжилгээ хийх газрыг оновчтой хуульчилсан эсэх?

Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1-д Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүргийг хуульчилсан ба мөн зүйлийн:

33.1.1.-д “аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх”,

33.1.2-т “олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах”,

⁵⁸ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 430-431 дэх тал.

⁵⁹ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 416 дахь тал.

33.1.3-т “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах”,

33.1.4-т “хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах” гэсэн заалтуудаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний чиг үүргийг томьёолсон нь Нэмэлт протоколын 19 дүгээр зүйлийн агуулгад нийцэж байна.

ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн Тайлбар хэсэг нь 33.1.1 заалтын “бүх газарт” гэх ойлголтод багтах байгууламж, газруудыг тодорхойлсон ба үүнд хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байр багтаж байна.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтаар Орлоцогч улсуудад өөрийн харьяа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээ авах үүрэг хүлээлгэсэн ба тус конвенцын 5 дугаар зүйлийн (а) хэсгийн “гэмт хэргийг тус улсын нутаг дэвсгэрт, эсхүл тус улсад бүртгэлтэй хөлөг онгоц буюу агаарын хөлөгт үйлдвэл”⁶⁰ гэсэн заалтаас тухайн улсын харьяаллын газар гэдэгт эдгээрийг багтааж ойлгох нь үндэслэлтэй болохыг илэрхийлж байна.

ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн Тайлбар хэсэгт “Монгол Улсад бүртгэлтэй хөлөг онгоц буюу агаарын хөлөг”-ийг хамааруулаагүй ба Нэмэлт протоколын 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “...харуул хамгаалалт бүхий нийтийн буюу хувийн” гэх харьяаллыг орхигдуулсан нь эрүү шүүлт явагдах боломжтой, хүн өөрийн хүслээр орхин явах боломжгүй газар, байгууламжийн хүрээг бүрэн хамраагүйг илтгэнэ.

Мөн “бүх газар” гэсэн ойлголтод “цэргийн сахилгын байр” гэж заасан нь ЭШУС үндэсний ажиллагаа нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх тогтмол хяналт шинжилгээг цэргийн ангид бус зөвхөн цэргийн сахилгын байранд хийхээр хязгаарласан заалт болжээ.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон түүний нэгжийн хяналт шинжилгээ хийх газар, байгууламжууд зөвхөн ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлд зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг дагаж мөрдөх зарчмын дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгж өөрийн очих шаардлагатай гэж үзсэн бусад газар, байгууламжид нэвтрэх боломж нээлттэй юм.

Иймд “бүх газарт” гэсэн ойлголтод харуул хамгаалалт бүхий нийтийн буюу хувийн байгууламжийг хамруулахын хамт Монгол Улсын далбаа бүхий агаарын болон усан замын хөлөг онгоц, бусад улсад оршин буй бүрэн эрхт төлөөлөгчийн газар, элчин сайдын яам, консулын газар, цэргийн анги, нэгтгэлийг багтааж, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон Нэмэлт протоколд нийцүүлэх нь зүйтэй.

⁶⁰ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц. 387 дахь тал.

3.4. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ БҮРЭН ЭРХИЙН БАТАЛГАА

Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах үүднээс Оролцогч улсууд энэ байгууллагад олгох баталгааг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 20 дугаар зүйлд тусгасан. Үүнд:

- (a) 4 дүгээр зүйлд заасан хорих газарт хоригдож байгаа хүмүүсийн тоо, хорих газрын тоо болон байршлын талаарх бүх мэдээллийг авах,
- (b) Тэдгээр хүнтэй харьцаж байгаа байдлын талаар болон тэдний хоригдож байгаа нөхцөлийн талаарх бүх мэдээллийг авах,
- (c) Бүх хорих газар, барилга, байгууламжид нэвтрэх,
- (d) Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй гэрч байлцуулалгүйгээр ганцаарчилсан эсхүл шаардлагатай гэж үзвэл хэлмэрчийн хамт, түүнчлэн үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын үзэж байгаагаар холбогдох мэдээлэл өгч магадгүй гэж үзсэн аливаа бусад этгээдтэй уулзаж, биечлэн ярилцлага хийх боломжтой байх,
- (e) Очих хүсэлтэй газар болон уулзах хүсэлтэй хүнээ чөлөөтэй сонгох эрхтэй байх,
- (f) Урьдчилан сэргийлэх дэд хороотой холбоотой байх, түүнд мэдээлэл өгөх болон дэд хороотой уулзах эрхтэй байх⁶¹ гэсэн заалтууд багтана.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХЭҮКтХ-ийн 34 дүгээр зүйл нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгжид олгосон бүрэн эрхийн хэм хэмжээтэй нийцсэн эсэх?

ХЭҮКтХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.1.-ээс 34.1.11. хүртэлх заалтуудаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуульчилсан.

Хэдий тийм боловч Нэмэлт протоколын 20 дугаар зүйлийн (f) заалтад дурдсан бүрэн эрхийг мөн хуулийн 34 дүгээр зүйлд агуулаагүй байна.

ХЭҮКтХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.8. хэсгийн “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх” гэсэн заалтыг Нэмэлт протоколын уг заалттай нийцэж байна гэхэд учир дутагдалтай.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 11 дүгээр зүйлээр НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороонд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилготой хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгосон ба

- 11 дүгээр зүйлийн 1-ийн (b) хэсгийн 2-т заасан “үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагатай шууд, шаардлагатай тохиолдолд нууц холбоотой байж тэдгээрийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор сургалт явуулж, техникийн туслалцаа үзүүлэх”,
- мөн хэсгийн 3-т заасан “эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг

⁶¹ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 431-432 дахь тал.

доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг хамгаалалтыг бэхжүүлэхэд шаардлагатай хэрэгцээ, арга замаа тодорхойлоход нь зөвлөгөө өгч, тусламж үзүүлэх”⁶² гэж заасан бүрэн эрхийнх нь хүрээнд НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороотой шаардлагатай тохиолдолд эрх баригчдын хөндлөнгийн оролцоогүйгээр “нууцын зэрэглэлтэй” харьцах, мэдээлэл өгөх, уулзах эрхийг хуульчлах нь зүйтэй.

Энэ нь Нэмэлт протоколын 12 дугаар зүйлийн (с) хэсгийн “Урьдчилан сэргийлэх дэд хороо болон үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын хоорондын харилцааг хөхиүлэн дэмжиж, түүнд дэмжлэг үзүүлэх”⁶³ гэсэн заалтаар Оролцогч улсуудад хүлээлгэсэн үүргийг давхар нөхөх ач холбогдолтой.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. ХЭҮКтХ-ийн 8 дугаар бүлгийн зохицуулалт нь Нэмэлт протоколоор ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгжид олгосон дархан эрхийн хэм хэмжээтэй нийцсэн эсэх?

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 35 дугаар зүйлд “...үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын гишүүд өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх ямба, дархан эрх эдэлнэ. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүд 1946 оны 02 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын 22 дугаар зүйлд заасан дархан эрх, ямбыг уг конвенцын 23 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасны үндсэн дээр эдэлнэ”⁶⁴ гэж заасан.

Дэд хороо энэ тухай Оролцогч улсуудад зориулан гаргасан удирдамждаа “Оролцогч улс нь урьдчилан сэргийлэх байгууллагын чиг үүргээ бие даан хэрэгжүүлэх боломжоор хангаж, гишүүд, ажилтнуудын халдашгүй байдал, дархан эрх, эрх ямба эдлэх нөхцөлөөр хангана”⁶⁵ гэж тусгажээ.

Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын гишүүд гэж Монгол Улсын ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгжийн ажилтнуудыг хэлэх ба эдгээр нь чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа болон дараа үүргээ бие даан хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль ёсны дархан эрх эдлэх ёстой.

Гэвч ХЭҮКтХ нь Нэмэлт протоколын 35 дугаар зүйлд заасан дархан эрхийг ЭШУС нэгжийн ажилтнуудад олгох зохицуулалт агуулаагүй байна.

ХЭҮКтХ-ийн 8 дугаар бүлэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний “албадан саатуулах, цагдан хорих болон зөрчлийн баривчлах шийтгэл ногдуулах, гэр, албан өрөө, биед нь үзлэг, нэгжлэг хийх” арга хэмжээ авахаас хамгаалагдах дархан эрхийг тусгасан боловч Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын 22 дугаар зүйлд заасан “бичиг баримтыг хураах, хянаж шалгах”, “харилцаанд саад учруулах”-аас хамгаалагдах бусад дархан эрхийг орхигдуулжээ.

⁶² “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 423 дахь тал.

⁶³ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 425 дахь тал.

⁶⁴ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 439-440 дэх тал.

⁶⁵ docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=6QkG1d%2FFPPRiCAqhKb7yhysquBIBCPFD%2BXL-NadyD9hiZ4SGqsp7QTjY12aNwfqi3CFkvYEqp%2BUSHT%2FCEAk5saRSeK0Q8FOnukz0hJM0206T%2FrtROW5qBoyJYZCbh7io7

Мөн хуулийн 8 дугаар бүлгийн 39 дүгээр зүйлийн 39.1 заалтад ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хамааралд нэгжлэг хийхийг хориглохдоо “тээврийн хэрэгсэл”, “дотоод болон гадаад албан томилолтоор ажиллах үед байрлах түр орон сууц”, “мэдээлэл агуулж байгаа хувийн болон албаны техник хэрэгсэл”-ийг тусгаагүй байна.

Дэд хорооны удирдамжид зааснаар “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь Дэд хорооноос оролцогч улсад хандаж гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, энэ талаар Дэд хороотой хамтарч ажиллах”⁶⁶ бүрэн эрхийг эдэлнэ.

ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагааг зохицуулах бүлэгт энэ тухай зохицуулалт тусгагдаагүй байгаа нь НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны зөвлөмжийн хэрэгжилтийг хянах субъектийн эрх зүйн чадамжийг бүрдүүлээгүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

3.5. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 19 дүгээр зүйлийн (b) хэсэгт “Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох хэм хэмжээг харгалзан эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй харьцах, тэдний байгаа нөхцөлийг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагад зөвлөмж өгөх⁶⁷ ...” гэж Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын чиг үүргийг тодорхойлсон ба 22 дугаар зүйлд “Оролцогч улсын холбогдох эрх бүхий байгууллага үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын зөвлөмжийг судалж, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авч болох арга хэмжээний талаар түүнтэй яриа хэлэлцээ хийнэ⁶⁸” хэмээн Зөвлөмжийг хүлээн авсан холбогдох байгууллагын үүргийг заасан.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХЭҮКтХ-ийн 35 дугаар зүйлийн зохицуулалт нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын шаардлагад нийцэх зорилгодоо хүрсэн эсэх?

ХЭҮКтХ-ийн 35 дугаар зүйлд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний Зөвлөмжид холбогдох харилцааны зохицуулалтыг хуульчилсан нь Нэмэлт протоколын 19 болон 22 дугаар зүйлтэй нийцэж байгаа боловч Дэд хорооны удирдамжид дурдсанчлан “Урьдчилан сэргийлэх байгууллагын гаргасан зөвлөмжийг Дэд хорооноос гаргасан санал, зөвлөмжүүд ба эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын бусад баримт бичигтэй нэгэн адил хүчинтэй гэж үз(нэ)эх⁶⁹” агуулга хангагдаагүй байгаа тул хуулийн холбогдох хэсэгт энэхүү үзэл баримтлалыг тусгах нь зүйтэй.

⁶⁶ docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=6QkG1d%2FPPRiCAqhKb7yhsquBIBCPFD%2BXL-NadyD9hiZ4SGqsp7QTjY12aNwFqi3CFkvYEqp%2BUSHT%2FCEAK5saRSeK0Q8FOnukzOhJMO2O6T%2FrtROW5qBoyJYZCbh7io7

⁶⁷ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 431 дэх тал.

⁶⁸ “Хүний эрхийн олон улсын билл” Монгол Улсын нэгдсэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол. 433 дахь тал.

⁶⁹ docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=6QkG1d%2FPPRiCAqhKb7yhsquBIBCPFD%2BXL-NadyD9hiZ4SGqsp7QTjY12aNwFqi3CFkvYEqp%2BUSHT%2FCEAK5saRSeK0Q8FOnukzOhJMO2O6T%2FrtROW5qBoyJYZCbh7io7

3.6. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЭШУС үндэсний ажиллагааны ил тод байдал нь хараат бусын нэг баталгаа болдог бөгөөд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 23 дугаар зүйлээр “Энэхүү протоколд оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын жил бүрийн тайланг хэвлэн нийтэлж, нийтэд түгээх үүрэг хүлээнэ” гэж заасан.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХЭҮКтХ-ийн 31 дүгээр зүйлийн зохицуулалт нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын шаардлагад нийцэх зорилгодоо хүрсэн эсэх?

ХЭҮКтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.4 хэсэгт “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хэвлэн нийтэлнэ” хэмээн зохицуулсан нь Нэмэлт протоколын 23 дугаар зүйлийн баталгааг хангах чухал заалт болжээ.

3.7. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮН БА ТҮҮНИЙ НЭГЖИЙН БУСАД ЭТГЭЭДТЭЙ ХАРЬЦАХ ХАРИЛЦААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 11, 12, 13, 14, 15, 16, 17, 19, 20, 21, 22, 23 дугаар зүйлүүдийн хүрээнд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгж нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрхлэхдээ үндэсний төрийн байгууллага, иргэний нийгэм, НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо, холбогдох олон улсын байгууллага болон бусад улсын ЭШУС үндэсний ажиллагаатай нягт уялдаатай, байнгын харилцаатай ажиллах шаардлагатай.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХЭҮКтХ-ийн 7 дугаар бүлэг нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын дээрх шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

ХЭҮКтХ-ийн:

- 11 дүгээр зүйлийн “Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар статистик мэдээллийг прокурорын байгууллагаас гаргуулах болон бусад хэлбэрээр хамтран ажиллана”,
- 26 дугаар зүйлийн 26.1.7 дахь хэсгийн “эрүү шүүлт явуулсан байж болзошгүй албан хаагчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх асуудлыг Улсын ерөнхий прокурорт уламжлах”,
- 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, хэвлэн нийтэлнэ”,
- 33 дугаар зүйлийн 33.1.3 дахь хэсгийн “эрүү шүүлтээс урьдчилан

- сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах”,
- 33.1.4 дэх хэсгийн “хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлсэн сурталчилгаа тогтмол явуулах” гэсэн заалтуудаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгж нь урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ,
 - түүнчлэн 34 дүгээр зүйлээр олгосон бүрэн эрхүүдээ эдлэхдээ,
 - 35 дугаар зүйлээр зохицуулсан Зөвлөмж, түүний хэрэгжилтийг хангах харилцаанд,
 - 38 дугаар зүйлд тусгасан эдийн засаг, нийгмийн,
 - 39 дүгээр зүйлд тусгасан хууль зүйн,
 - 40 дүгээр зүйлд тусгасан аюулгүй байдлын баталгааг эдлэхдээ дээр дурдсан байгууллага, этгээдтэй тус бүрд холбогдох процессын харилцаа үүсгэж, хамтран ажилладаг.

Хэдий тийм боловч ХЭҮКтХ-ийн ЭШУС үндэсний ажиллагаанд холбогдох бүлэгт түүний бусад байгууллага, этгээдтэй харилцах, хамтран ажиллах зохицуулалт огт тусгагдаагүй байгаа нь анхаарал татаж байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хийж буй тогтмол хяналт шинжилгээ болон бусад үйл ажиллагааны үр дүнд үндэслэн цаашид бодлогын болон зохион байгуулалтын ямар арга хэмжээ авах талаар үндэсний болон олон улсын хэмжээнд үр дүнтэй яриа хэлэлцээрийг бүх шатанд хийх нь ЭШУС үндэсний ажиллагааны Нэмэлт протоколоор хүлээсэн чухал үүрэг юм.

Иймд хуульд шинэ зүйл нэмэх замаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгжийн бусад этгээдтэй харилцах харилцааг зохицуулах нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. ХЭҮКтХ-ийн 7 дугаар бүлэг нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 13, Нэмэлт протоколын 21 дүгээр зүйлүүдэд дурдсан эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол, мэдээлэл өгсөн, ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах хувь хүн, байгууллагын баталгааг хангах шаардлагад нийцсэн эсэх?

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 13 дугаар зүйл “... Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авна”, Нэмэлт протоколын 21 дүгээр зүйлийн 1 ба 2 дахь хэсэг “Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагад мэдээлэл өгсөн хувь хүн, байгууллагад тэр мэдээлэл нь үнэн, худлыг эс харгалзан ямар ч эрх бүхий байгууллага, албан тушаалтан ямарваа шийтгэл ногдуулахыг тушаах, эдлүүлэх, зөвшөөрөх, хүлээн тэвчих ёсгүй бөгөөд тухайн хувь хүн, байгууллагыг ямарваа бусад байдлаар хавчих ёсгүй”, “Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын цуглуулсан нууц мэдээллийг ил тод болгох ёсгүй. Хувь хүний тухай мэдээллийг тухайн хүний шууд илэрхийлсэн зөвшөөрөлгүйгээр нийтлэх ёсгүй” гэсэн заалтуудаар эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол, мэдээлэл өгсөн, ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах хувь хүн, байгууллагын баталгааг хангахыг Оролцогч улсуудад үүрэг болгосон.

ХЭҮКтХ-д ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах хувь хүн, байгууллагын баталгааг хангах ямарваа заалт тусгагдаагүй байгаа нь “ноцтой” гэж дүгнэгдэж байна.

Иймд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгжийн бусад этгээдтэй харилцах харилцааг шинэ бүлэгт зохицуулахдаа хэлмэгдэхээс хамгаалах асуудлыг тусгах нь зүйтэй байна.

3.8. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. ХЭҮКтХ-ийн 41 дүгээр зүйл нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хориглох зүйлийг ХЭҮКтХ-ийн 41 дүгээр зүйлд хуульчилсан ба 41.1.2 дахь хэсгийн “энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглах” гэсэн заалт нь ЭШУС үндэсний ажиллагааны эсрэг урвуулан ашиглагдах эрсдэлтэй байж болзошгүй тул уг заалтын хууль хэрэглээний үл ойлгогдох байдалд дахин дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Нэг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулах Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн зорилт, хэм хэмжээ нь **Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколын шаардлагыг хангаж, нийцүүлсэн эсэхэд** хийсэн дүн шинжилгээний хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг 1, 3, 6, 7, 8 дугаар бүлгийн 22 заалтаар үнэлбэл Зорилгод хүрсэн байдал нь 50 хувь, Практикт нийцэж буй байдал нь 22.7 хувь байна.

Хүснэгт 2. Үнэлгээний хураангуй

№	Үнэлэх бүлэг	Зорилгод хүрсэн байдал	Практикт нийцэж байгаа байдал
<i>Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл</i>			
<i>/Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол ба ХЭҮК-ийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын нийцэл/</i>			
1	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1. заалт	Үгүй	Үгүй
2	5 дугаар зүйл. Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо 5.1. заалт	Үгүй	Үгүй
3	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.2. заалт	Тийм	Тийм
4	7 дугаар бүлэг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа	Тийм	Тийм
5	32 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн	Тийм	Үгүй
6	19 дүгээр зүйл. Комиссын даргын бүрэн эрх 19.1.10 заалт	Үгүй	Үгүй

7	36 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж 36.1 заалт	Үгүй	Үгүй
8	36 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж 36.3 заалт	Үгүй	Үгүй
9	31 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа 31.2. заалт	Тийм	Үгүй
10	39 дүгээр зүйл. Хууль зүйн баталгаа 39.3. заалт	Тийм	Үгүй
11	34 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх	Тийм	Үгүй
12	31 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа 31.3. заалт	Тийм	Үгүй
13	38 дугаар зүйл. Эдийн засаг, нийгмийн баталгаа 38.1. заалт	Тийм	Үгүй
14	6 дугаар зүйл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 6.2. заалт	Үгүй	Үгүй
15	33 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиг үүрэг	Тийм	Тийм
16	33 дугаар зүйл. Тайлбар хэсэг	Үгүй	Үгүй
17	34 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрх 34.1.8. заалт	Үгүй	Үгүй
18	8 дугаар бүлэг. Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүрэн эрхийн баталгаа 39.1. заалт	Үгүй	Үгүй
19	35 дугаар зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж	Тийм	Тийм
20	31 дүгээр зүйл. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаа 31.4. заалт	Тийм	Тийм
21	7 дугаар бүлэг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа	Үгүй	Үгүй

22	41 дүгээр зүйл. Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд хориглох зүйл 41.1.2. заалт	Үгүй	Үгүй
	Нийт/хувь	11/11	5/17
		50%	22.7%

НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орж, түүний Нэмэлт протоколын 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр соёрхон баталж, 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ. Хэдий тийм боловч Монгол Улсын нэгдэж орсон тус конвенцыг албан ёсоор Төрийн мэдээлэл сэтгүүл⁷⁰, Нэмэлт протоколыг Төрийн мэдээлэл сэтгүүл⁷¹ болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд нийтлээгүй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 43.2 дахь заалт⁷²-ыг зөрчсөн байх тул энэ асуудлыг анхааралдаа авч, хуулийн дагуу хэвлэн нийтэлж, иргэдийг мэдээлэл авах боломжоор бүрэн хангах нь зүйтэй юм.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль нь Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” зорилгоор тогтмол хяналтын тогтолцоог бий болгох, үүний тулд Комисст нэмэлт чиг үүрэг оноон, шинэ бүтэц үүсгэх замаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг байгуулах, түүний үйл ажиллагааг зохицуулах ач холбогдолтой хууль юм.

Гэвч уг хуулийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй төдийгүй, ЭШУС үндэсний ажиллагаа чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл, үл ойлгогдох байдал үүсгэхүйц байгаа нь энэхүү дүн шинжилгээгээр тогтоогдож байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протокол нь Оролцогч улсууд үр дүнтэй урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах, ингэхдээ түүний үйл ажиллагааны болон санхүүгийн хараат бус байдлыг хангахыг холбогдох заалтууд, зөвлөмж, удирдамжууддаа дурджээ.

Хэдийгээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагаа (г)” ойлгоно” хэмээн ЭШУС үндэсний ажиллагааг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын суурь зарчмын агуулгад нийцүүлэн томъёолоод, 7 дугаар бүлгээр энэхүү хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг зохицуулсан боловч 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлийн “Хуулийн зорилт” хэсэгт хуулийн уг зохицуулалтын агуулга тусгагдаагүй байгаа нь ХЭҮКТХ-ийн нэг заалт нөгөө

⁷⁰ Төрийн мэдээлэл №42/179/ (parliament.mn)

⁷¹ Төрийн мэдээлэл №47/860/ (parliament.mn)

⁷² Хууль тогтоомжийн тухай хуулийн 43 дугаар зүйл. 43.2 дахь заалт “Монгол Улсын олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийг соёрхон баталсан гэрээний хамт “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.”

заалтаа хангаагүй, нөхөөгүй, орлоогүй, тусгахгүй орхигдуулсан ба үгүйсгэсэн, сулруулсан, зөрчсөн шинжтэй хэд хэдэн зүйл заалтуудын нэг илрэл болж байна.

ХЭҮКтХ-д Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах тогтолцоог зохицуулах 2 дугаар бүлгийн 5 дугаар зүйлд түүний бүрэлдэхүүнийг хэрхэн тодорхойлсон нь оновчтой бус хэмээн дүгнэлээ.

Хүн төрөлхтөн нийтээр хүлээн зөвшөөрсөн анхны баримт бичиг бол Хүний эрхийн түгээмэл тунхаглал юм. НҮБ-д элссэн цаг мөчөөс Оролцогч улс бүр Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тусгасны дагуу хүний эрүү шүүлтээс ангид байх жам ёсны эрхийг үл хязгаарлах үүргийг хүлээдэг. Энэ утгаар Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах тогтолцоонд хүний эрүү шүүлтээс ангид байх жам ёсны, ямар ч үед үл хязгаарлагдах, онцгой эрхийг хамгаалах, хангах зорилгоор урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эрхэлдэг тогтолцоо буюу Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг багтаах нь зүй ёсны асуудал болов уу.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол нь урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагын буюу Монгол Улсын тухайд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн болон түүний нэгжийн албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, үндэсний ажиллагааны хүний нөөцийн бүрдүүлэлтэд баримталбал зохих хэм хэмжээ, шаардлагыг тодорхой тусгасан.

Нэмэлт протоколд хэрэглэж байгаа “Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага”-ын шинжээчид, гишүүд гэсэн нэр томъёо нь Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагааны тухайд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн ба түүнд туслах нэгжийн албан хаагчид юм. Гэтэл ХЭҮКтХ-ийн холбогдох зохицуулалтууд нь нэг талаас ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд тавигдах боловсрол, ажил, мэргэжлийн ур чадвар, туршлага зэрэг олон шалгууруудыг заасан боловч үндэсний ажиллагааны бүрэлдэхүүнд хамаарах албан хаагчид буюу нэгжийн хүний нөөцийн бүрдүүлэлтийн зохицуулалтыг агуулаагүй байгаа нь дээр дурдсанчлан нэгдмэл агуулгын нэг талыг тусгасан боловч нөгөө талыг хуульд заалгүй орхигдуулсан тохиолдлын нэг жишээ юм.

ХЭҮКтХ-д хууль хэрэглээнд үл ойлгогдох байдал үүсгэсэн хэд хэдэн заалт тусгагджээ. Тухайлбал, 19 дүгээр зүйлийн 19.1.10-т “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх” гэж Комиссын даргын бүрэн эрх хэсэгт заасан нь хуулийн нэг заалт нөгөөхөө үгүйсгэх шинжийг агуулжээ гэж дүгнэж болохоор байна.

ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн дотоод үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам баталж мөрдүүлэх бүрэн эрхийг хуулиар олгосон боловч хуулийн энэхүү заалтаа даган гарах зохицуулалтыг хийхдээ түүнд туслах нэгжийн албан хаагчдыг Комиссын Тамгын газарт харьяалуулж, Хөдөлмөрийн дотоод журмаар бусад дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон нь хуулийн 31.2 хэсгийн “хөндлөнгийн нөлөөлөл, оролцоо”-оос ангид байхыг хангасан заалтаа үгүйсгэж, энэ нь практик дээр хүндрэл бэрхшээл, үл ойлгогдох байдал үүсгэж байгааг алба хаагчидтай хийсэн ярилцлагаас харж болно.

ЭШУС үндэсний ажиллагааны албан хаагч ярилцлагадаа "...ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний шийдвэрлэж, зохицуулалт хийсэн дотоод зохион байгуулалтын асуудлыг ХЭҮК-ын зүгээс хүлээн зөвшөөрдөггүй, үүнээс үүдэж албан хаагчид бидэнд өдөр тутмын үйл ажиллагаагаа саадгүй явуулахад төвөгтэй асуудал үүсдэг" гэж дурдсан.

ЭШУС үндэсний ажиллагааны чухал баталгаа нь санхүүгийн хараат бус байдал юм.

"ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд өөрийн үйл ажиллагаанд зориулагдсан санхүүжилтийг бие даан хуваарилах боломжийг олгох замаар Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын санхүүгийн бие даасан байдлыг хангах" тухай зөвлөмжийг НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо болон Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг Монгол Улсад хийсэн айлчлалуудынхаа мөрөөр Засгийн газарт хүргүүлсэн 3 удаагийн зөвлөмжүүдэд удаа дараа дурдсан байгаатай энэхүү дүн шинжилгээг хийх явцдаа танилцлаа.

Эдгээр зөвлөмжүүд нь 2017, 2022 онуудад хийсэн айлчлалуудын мөрөөр ирсэн байгаа нь анхаарал татаж байна. Айлчлалууд хооронд 5 жилийн хугацаа өнгөрсөн байхад ЭШУС үндэсний ажиллагааны үйл ажиллагааны болон санхүүгийн хараат бус байдал хангагдаагүй, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний нэгжийн албан хаагчдаа сонгох, хүний нөөцийн бүрдүүлэлтэд бага эрх мэдэлтэй байгаа асуудал шийдэгдээгүй, ямар нэг байдлаар дээрдээгүй байгаа нь анхаарал татаж байна.

ХЭҮКтХ-д зааснаар ХЭҮК болон ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь хэн алинаасаа хараат бус, бие даасан хоёр институт байхаар хуульчлагдсан ба хуулийн "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна", "Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана" гэх заалтууд ЭШУС үндэсний ажиллагааны төсөв ХЭҮК-ийн төсвөөс тусдаа байхыг илэрхийлнэ.

ХЭҮКтХ-д зааснаар ХЭҮК болон ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь санхүү, төсвийн хувьд нэгдмэл нэг төрийн сантай байдаг. Нэг төрийн сантай учраас санхүүгийн гүйлгээ хийхэд нэг болон хоёрдугаар гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтнууд нь ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх зэрэг нөхцөл байдал үүсгэх боломжтой байна.

Хэдийгээр ХЭҮКтХ-ийн 31.3; 38.1 дэх хэсгийн зохицуулалтууд ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны эдийн засгийн баталгааг хангасан боловч, "Нээлттэй нийгэм форум" Төрийн бус байгууллагын дээрх судалгааны дүнд тогтоогдсон Монгол Улсын Төсвийн тухай хуулиар зохицуулагдаж буй төсвийн байгууллагын төсвийн харилцаа, Гадаадын зээл, тусламж, хандивын хөрөнгийг захиран зарцуулалтын харилцаа болон ХЭҮКтХ-д ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь бие даасан төсөвтэй байх талаар зохицуулалтыг агуулаагүй зэрэг баримтууд нь Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны санхүүгийн хувьд хараат бус байх баталгааг хангах үүрэг хууль, эрх зүйн орчны оновчтой бус зохицуулалтын улмаас хангалтгүй хэрэгжиж байгааг илтгэж байна.

ХЭҮКтХ-ийн 33 дугаар зүйлийн Тайлбар хэсэгт “Монгол Улсад бүртгэлтэй хөлөг онгоц буюу агаарын хөлөг”-ийг хамааруулаагүй ба Нэмэлт протоколын 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “...харуул хамгаалалт бүхий нийтийн буюу хувийн” гэх харьяаллыг орхигдуулсан, Нэмэлт протоколын 35 дугаар зүйлд заасан ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнд хамаарах дархан эрхийг хуулийн холбогдох хэсэгт бүрэн тодотгоогүй, нэгжийн ажилтнуудад Нэмэлт протоколоор олгосон зохих эрхүүдийг олгох зохицуулалтыг агуулаагүй, НҮБ-ын ЭШУС Дэд хороотой шууд, нууцын зэрэглэлтэй харилцах болон бусад олон улсын болон холбогдох этгээдүүдтэй харилцах харилцааны зохицуулалтыг орхигдуулсан, ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг НҮБ-ын ЭШУС Дэд хорооноос гаргасан санал, зөвлөмжүүд ба эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын бусад баримт бичигтэй нэгэн адил хүчинтэй гэж үзэх зарчмыг тусгаагүй зэрэг нөхцөл байдлууд энэхүү шинжилгээгээр илрээд байна.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол, мэдээлэл өгсөн, ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах хувь хүн, байгууллагын баталгааг хангах үүргийг Монгол Улс хүлээсэн. Гэтэл ХЭҮКтХ-д ЭШУС үндэсний ажиллагаатай хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах хувь хүн, байгууллагын баталгааг хангах ямарваа заалт тусгаагдаагүй байгаа нь “ноцтой” юм.

Монгол Улс ХЭҮК-ын олон жилийн туршлага дээр үндэслэн улсын харьяаллын нутаг дэвсгэрт хүний эрхийг хязгаарласан газруудад байнгын хяналт шинжилгээ хийх тогтолцоог шинэ бүтэц бий болгох замаар байгуулсан нь анхлан байгуулагдсан ЭШУС үндэсний ажиллагаа төрийн байгууллага, иргэдэд танигдах, бүрэн эрхээ тэднээр зөвшөөрүүлэх давуу талтай байсан нь гарцаагүй юм. Ийм бүтцээр байгуулагдахад ХЭҮК нь цагдан хорих газруудад хяналт тавих хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд тодорхой туршлага хуримтлуулсан байдал нь давуу тал болдог боловч олон сорилтыг бий болгож байгаа ажиглагдлаа.

Хуулийн хэрэгжилтийн явцад практикт үл нийцэх зохицуулалтууд сөрөг үр дагавраа гаргаж байгааг албан хаагчдын ярилцлагууд гэрчилж байна.

“Одоогийн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хуулиудын зохицуулалтаар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь үйл ажиллагаандаа зориулагдсан төсвийг захиран зарцуулах боломжгүй болж, үндэсний ажиллагааны санхүүгийн хараат бус байдал хангагдах нөхцөл бүрдээгүй” хэмээн нэгжийн албан хаагч яриад, үндэсний ажиллагааны Нэмэлт протоколоор хүлээсэн тогтмол хяналт шинжилгээ хийх чиг үүргийн хэрэгжилтэд санхүүгийн хувьд хараат байгаа байдал саад учруулдаг тухай дурдсан.

Зарим Оролцогч улс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааныхаа хууль, эрх зүйн орчинд шинэчлэл хийж, ХЭҮК-ын дэргэд байгуулагдсан хуучин бүтцээ бие даасан байгууллагын хэлбэрт шилжүүлэн байгуулсан жишээг ЭШУС үндэсний ажиллагааны бэлтгэсэн мэдээллээс⁷³ авлаа. Тухайлбал, Бүгд Найрамдах Маврикий улс нь Хүний эрхийн Үндэсний Байгууллагынхаа хууль эрх зүйн үндэслэлийг дахин хянаж үзээд, 2007 онд энэ статусыг өөрчилж, бие даасан байгууллага хэлбэрээр 2014 онд шинэчлэн байгуулж байжээ. Мөн Мексикийн Нэгдсэн Улс нь 2007 онд Хүний эрхийн

⁷³ Монгол Улсын ЭШУС үндэсний ажиллагаанаас ирүүлсэн мэдээллээс

Үндэсний Байгууллагынхаа дэргэд байгуулсан боловч, 2017 онд бие даасан статусаар шинэчлэн байгуулсан гэх зэргээр хэд хэдэн Оролцогч улс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааныхаа бие даасан, хараат бус байдлыг бүрэн хангаж, урьдчилан сэргийлэх чиг үүргээ илүү үр дүнтэй, хүртээмжтэй явуулах аргыг сонгож байна.

Монгол Улс нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд байгуулсан нь уг механизмын НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколоор олгосон тусгай бүрэн эрхүүд болон Хүний эрхийн Үндэсний Комиссын өргөн хүрээний бүрэн эрхийн хооронд төөрөгдөл, харилцан уялдахгүй байдал үүсгэж, улмаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагааны болон санхүүгийн хараат бус байх бүрэн эрхийн баталгааг Комиссын удирдлагын зүгээс хангахгүй байх зэрэг олон бэрхшээлийг үүсгэж, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилтэд саад учруулж байж болзошгүй гэх дүгнэлтэд хүргэж байна.

Иймд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг улсын харьяаллын бүхий л нутаг дэвсгэрт үр дүнтэйгээр хараат бусаар явуулах чадамжтай, өөрийн гэсэн захиргаа, санхүүгийн удирдлага бүхий, НҮБ-ын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх баримт бичгүүдийн шаардлагад нийцсэн, үйл ажиллагааны болон санхүүгийн бүхий л нөөцөөр бүрэн хангагдсан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан байгууллага байгуулах замаар НҮБ-ын гэрээний хороодоос удаа дараа Монгол Улсад хүргүүлж байгаа зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, ингэснээр Монгол Улсын иргэн бүрийн эрүү шүүлтээс ангид байх эрх төрийн аль ч шатанд үл зөрчигдөх, хязгаарлагдахгүй байх, цаашлаад Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээг шударгаар сахин биелүүлэх амлалтаа биелүүлэх стратегийн чухал алхам болох билээ.

ЗӨВЛӨМЖ

1) Монгол Улсын нэгдсэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т заасны дагуу “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэхийг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколыг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэхийг Улсын Их Хурлын Тамгын газарт, мөн тус хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-д заасны дагуу Эрх зүйн мэдээлийн системд байршуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яамад тус тус хандах;

2) Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан байгууллага байгуулах тухай хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх;

3) Дараах олон улсын эрх зүйн хэм хэмжээг хуулийн төслийн эрх зүйн зохицуулалтыг боловсруулахдаа баримтлах. Үүнд:

1) Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бие даасан үндэсний ажиллагаа / цаашид “Бие даасан байгууллага” гэх/-г байгуулах тухай хуулийн үндэслэлийг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын хэм хэмжээтэй уялдуулан тодорхойлох;

2) Бие даасан байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдлыг бүрэн хангах;

3) Бие даасан байгууллагын санхүүгийн хараат бус байдлыг бүрэн хангах;

4) Бие даасан байгууллагын үйл ажиллагаагаа явуулах бүхий л нөөцийг төрөөс бүрэн хангах. Үүнд:

4.1. Хүний нөөц;

4.2. Үйл ажиллагаагаа эрхлэн явуулах оффис;

4.3. Тогтмол, хэдийд ч хяналт шинжилгээгээр явахад хүрэлцэхүйц, техникийн хүчин чадал бүхий өөрөө явагч техник, хэрэгсэл;

4.4. Хяналт шинжилгээний хүрээнд нөхцөл байдлын баримтжуулалт хийх болон олон нийтэд мэдээлэл түгээх техник, хэрэгсэл;

5) Бие даасан байгууллагын хяналт шинжилгээ хийх бүхий л газрыг хамруулан оновчтой тодорхойлох. Үүнд одоогийн ХЭҮКтХ-д нэрлэсэн газруудаас гадна:

5.1. Харуул хамгаалалт бүхий нийтийн буу хувийн байгууламж;

5.2. Монгол Улсын далбаа бүхий агаарын хөлөг онгоц;

5.3. Монгол Улсын далбаа бүхий усан замын хөлөг онгоц;

5.4. Бусад улсад оршин буй бүрэн эрхт төлөөлөгчийн газар;

5.5 Бусад улс дахь Монгол Улсын Элчин сайдын яам, консулын газар;

5.6. Цэргийн анги, нэгтгэл.

6) Бие даасан байгууллагын бүрэн эрх, дархан эрхийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын хэмжээнд нийцүүлэн олгох;

7) Бие даасан байгууллагын Зөвлөмжийн заавал биелэгдэх шинж, түүнийг НҮБ-ын эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг баримт бичиг болон НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Зөвлөмжийн нэгэн адил хүчинтэй гэж үзэх агуулгыг тусгах;

8) Бие даасан байгууллагын бусад этгээдтэй харилцах харилцааг зохицуулах;

9) Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх байгууллагатай хамтран ажилласныхаа төлөө хэлмэгдэхээс хамгаалагдах хувь хүн, байгууллагын баталгааг хангах зэрэг.

Хоёр. Монгол Улсын холбогдох хууль ба Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын нийцэлд хийсэн судалгаанд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Улс орнууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүнээр элссэнээрээ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын дагуу “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй” (5 дугаар зүйл) гэсэн заалтыг биелүүлэх амлалтыг дэлхий нийтийн өмнө авдаг. 1984 оны НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц нь Оролцогч улсуудад энэхүү амлалтаа биелүүлэхийн тулд эрүү шүүлтийг үр дүнтэй хориглох, урьдчилан сэргийлэх чухал үүргүүдийг нарийвчилсан заалтууддаа тусгасан.

Монгол Улс нь нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэхээ Монгол Улсын Үндсэн хуулийн 10.2, 10.3 заалтад тусган хуульчилжээ. Улмаар Монгол Улс нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зохицуулалтыг холбогдох хууль, эрх зүйн орчинд нэмэлт өөрчлөлт хийх замаар тусгасан ба эдгээр зохицуулалт нь конвенц, түүний Нэмэлт протоколд хэрхэн нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц нь эрүүдэн шүүхийг туйлын хориглох; түүнээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх; эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг орхигдуулалгүй шалгаж, ял шийтгэл оногдуулах; эрүү шүүлтийн хохирогчдод шударга, хангалттай нөхөн төлбөр олгох; конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан алхмуудаа тодорхойлсон тайланг гаргаж байх гэсэн үндсэн таван үүргийг Оролцогч улсуудад хүлээлгэжээ.

Монгол Улс нь Үндсэн хууль, Монгол Улсын ХЭҮКТХ, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид “ЭХХШТХ” гэх/, Онц байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /цаашид “ШШГТХ” гэх/, Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Өршөөл үзүүлэх тухай хууль, Шүүх шинжилгээний тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Иргэний хуулиудын зүйл, заалтуудаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор хүлээлгэсэн дээрх таван үүргүүдийн хэрэгжилтийг хангах эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан байна.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалтууд нь НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцтой нийцэж байгаа эсэхийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг харгалзан, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран “Зорилгод хүрсэн түвшин” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт

Үнэлэх хүрээ	Хуулийн зүйл, заалт	Шалгуур үзүүлэлт
Монгол Улсын холбогдох хуулиуд болон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын нийцэл	Монгол Улсын Үндсэн Хууль - 16.13	Зорилгод хүрсэн түвшин
	Монгол Улсын Үндсэн Хууль - 19.2	
	Онц байдлын тухай хууль - 18	
	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 1.9.1	
	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 1.9.2	
	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 16.14.4	
	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 29.5.1.1	
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - 7.3	
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - 273.2.2	
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - 273.2.7	
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - 273.2.12	
	Цагдаагийн албаны тухай хууль - 22.4	
	Цагдаагийн албаны тухай хууль - 69.1.2	
	Цагдаагийн албаны тухай хууль -69.1.7	
	Цагдаагийн албаны тухай хууль - 69.1.12	
	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль - 3.2	
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль - 4.8.7		
Гамшгаас хамгаалах тухай хууль - 10.9.4		

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль - 11.1.4
Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль - 3.2
Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хууль - 7.1.7
Эрүүгийн хууль - 1.7.3
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 43.3.1.6
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 16.12.1
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 16.12.2
Эрүүгийн хууль - 21.12
Эрүүгийн хууль - 6.6.1.1
Эрүүгийн хуулийн Ерөнхий анги -1.5
Эрүүгийн хуулийн Ерөнхий анги - 1.6
Монгол Улсын Үндсэн хууль - 16.14
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 15.1.2
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 31.8.1.8
Өршөөл үзүүлэх тухай хууль - 9 дүгээр зүйл
Монгол Улсын Үндсэн хууль - 16.14
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 45.1
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 45.2.1
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 45.2.2.5
Засгийн газрын тусгай сангийн тухай хууль - 10.3
Шүүх шинжилгээний тухай хууль - 40.1
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 45.4
Иргэний хууль - 228
Иргэний хууль - 229
Иргэний хууль - 230

2.1. “ТУЙЛЫН ХОРИГЛОХ”: Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг туйлын хориглосон статус нь олон улсын эрх зүйн үл хязгаарлах зарчим юм. Энэ хориг нь Оролцогч улсуудад “эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхгүй байх” (1 дүгээр зүйл), хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж болзошгүй газар руу явуулахгүй байх (3 дугаар зүйл), түүнчлэн эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгийг нотлох баримт болгохгүй байх үүргийг багтаасан болно (15 дугаар зүйл). Мөн Оролцогч улсууд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг туйлын хориглохыг дотоодын хууль тогтоомждоо зохих ёсоор тусгаж, холбогдох төрийн албан тушаалтны сургалтын хэрэглэгдэхүүнд тусгах ёстой болохыг 10 дугаар зүйлд тусгасан.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.13, 19.2, Онц байдлын тухай хуулийн 18, ЭХХШТХ-ийн 1.9.1; 1.9.2, 16.14.4, 29.5.1.1, ШШГТХ-ийн 7.3, 273.2.2, 273.2.7, 273.2.12, Цагдаагийн албаны тухай хуулийн 22.4, 69.1.2, 69.1.7, 69.1.12, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 3.2, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.9.4, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийг засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11.1.4, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3.2 заалтууд нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлийн “эрүүдэн шүүхийг туйлын хориглох зарчимд” нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

Монгол Улс нь Үндсэн хуулийн 16.13 заалтаар эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг доромжлохыг туйлын хориглосон ба мөн хуулийн 19.2; Онц байдлын тухай хуулийн 18 дахь заалтуудад энэ хориг нь онц болон дайны байдал зарласан тохиолдолд ч үл хөндөгдөхийг хуульчилсан.

Түүнчлэн, ЭХХШТХ-ийн 1.9.1; 1.9.2 заалтуудаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлох”-ыг,

-“Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэх”-ийг;

-16.14.4 заалтаар “нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ иргэний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг бусад арга хэрэглэх”-ийг;

-29.5.1.1 заалтаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад “хүний нэр төр, алдар хүндийг гутаах, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, эрүүдэн шүүх”-ийг;

-ШШГТХ-ийн 7.3 заалтаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох”-ыг;

-273.2.2 заалтаар “албан тушаал, байгууллагын нэрээр бусдыг эрхшээлдээ оруулах, дарамтлах”-ыг;

-273.2.7 заалтаар “бусдыг хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг уриалах, чиглүүлэх, шууд болон шууд бус хэлбэрээр өдөөн хатгах, оролцох”-ыг;

-273.2.12 заалтаар “гэмт хэрэг, зөрчлийн талаар хүнээс мэдээлэл, тайлбар авах зорилгоор эрүүдэн шүүх, эсхүл ийм үйлдлийг аливаа хэлбэрээр зөвтгөх”-ийг;

-Цагдаагийн албаны тухай хуулийн 22.4 заалтаар “Цагдаагийн албан хаагч бусдад эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлох”-ыг;

-69.1.2 заалтаар “албан тушаал, байгууллагын нэрээр бусдыг эрхшээлдээ оруулах, дарамтлах”-ыг;

-69.1.7 заалтаар “бусдыг хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийхийг тулгах, уриалах, чиглүүлэх, шууд болон шууд бус хэлбэрээр өдөөн хатгах, оролцох”-ыг;

-69.1.12 заалтаар “гэмт хэрэг зөрчлийн талаар хүнээс мэдээлэл, тайлбар авах зорилгоор эрүүдэн шүүх, эсхүл ийм үйлдлийг аливаа хэлбэрээр зөвтгөх”-ийг

-Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 3.2 заалтаар “Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, эсхүл бусад арга хэрэглэн түүнийг бие махбодыг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтад оруулахыг”

-Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8.7 заалтаар “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, эсхүл хүний нэр төрийг гутаан доромжлон харьцаж мэдүүлэг авахыг” тус тус хориглож,

-Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.9.4 заалтаар гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөхдөө “хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөнддөөгүй байх”-ыг хангахыг,

-Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийг засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11.1.4 заалтаар эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргах, арга хэмжээ хэрэгжүүлэхдээ “хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөнддөөгүй байх”-ыг хангахыг,

-Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3.2 заалтаар “Гэрч хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалтад байгаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх ... эрхийг хязгаарлахгүй” гэж хуульчилсан нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлийн “эрүүдэн шүүхийг туйлын хориглох зарчимд” бүрэн нийцжээ.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Монгол Улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.1.7, заалт нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын “эрүүдэн шүүхийг туйлын хориглох зарчимд” нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

Конвенцод тодорхойлсноор “эрүүдэн шүүх” үйлдэлд төрийн албан тушаалтан шууд ба шууд бусаар оролцсон байх шинжийг агуулсан нь энэ хэргийн субъект нь зөвхөн шүүх эрх мэдлийн, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх

байгууллагын албан тушаалтнуудаар хязгаарлагдахгүй, хүний эрх чөлөөг хассан, тухайн этгээд өөрийн дураар орхин гарч явах боломжгүй, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдэл явагдаж болзошгүй бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, байгууламж, газруудын албан хаагч, ажилтан ч энэ үйлдлийн субъект болж болохыг конвенцын 1,4 болон Нэмэлт протоколын 4 дүгээр зүйлд заасан.

Монгол Улс нь эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг доромжлохыг ЭХХШТХ, ШШГТХ, Цагдаагийн албаны тухай хуулиудаар шүүх эрх мэдлийн, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан тушаалтнуудад хориглосон боловч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын албан хаагч, ажилтан, хуулийн этгээдэд хориглох зохицуулалтыг бусад холбогдох хуулиудад тусгаагүй байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.1.7 заалтад “албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх”-ыг төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээнд багтаасан нь “эрүүдэн шүүх” үйлдэлд тооцогдохгүй, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах үйлдэлд зарим талаар хамаарч байгаа боловч бүхэлд нь туйлын хориглох Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын зарчмыг хангахгүй байна.

Иймд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Зөрчлийн тухай хуулиудад нэмэлт бүлэг, зүйлчлэл тусгах замаар төрийн бусад байгууллагын болон хувийн хэвшлийн албан хаагч, ажилтан, иргэнд эрүүдэн шүүх үйлдэлд тооцогдохгүй, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах үйлдлийг хориглох хуулийн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.7.3; ЭХХШТХ-ийн 43.3.1.6 заалтууд нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын “эрүүдэн шүүх аюул тулгарна гэж үзэх хангалттай үндэслэл байвал” тухайн хүнийг буцаах буюу шилжүүлэн өгөхгүй байх зарчимд нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын “туйлын хориглох” зарчмын нэг нь 3 дугаар зүйлд тусгасан “эрүүдэн шүүх аюул тулгарна гэж үзэх хангалттай үндэслэл байвал” тухайн хүнийг буцаах буюу шилжүүлэн өгөхгүй байх хориг юм. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.7.3; ЭХХШТХ-ийн 43.3.1.6 заалтууд нь конвенцын уг зарчмыг бүрэн хангаж нийцжээ.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Монгол Улсын ЭХХШТХ-ийн 16.12.1, 16.12.2 заалтууд нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын “туйлын хориглох зарчим”-д нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 15 дугаар зүйл нь эрүү шүүлтийн улмаас хийсэн гэж тогтоогдсон мэдэгдлийг шүүн таслах аливаа ажиллагаанд нотлох баримт болгохгүй байх хоригийг Оролцогч улсуудад хүлээлгэсэн байна.

Монгол Улсын ЭХХШТХ-ийн 16.12.1 заалт нь уг хоригийг хангахаар зохицуулахдаа зөвхөн эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгийг нотлох баримтад тооцохгүй байхаар тусгасан нь мэдүүлгээс бусад нотлох баримтыг эрүү шүүлт

тулгаж авсан ч нотлох баримтын хэмжээнд үнэлж болох агуулгыг илэрхийлж, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын “туйлын хориглох” зарчмыг зөрчжээ.

Иймд ЭХХШтХ-ийн 16.12.1, 16.12.2 заалтуудыг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын зарчимд нийцүүлэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар өөрчлөх зүй ёсны шаардлага үүсэж байна.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 15 дугаар зүйлд төрийн албан тушаалтны сургалтын хэрэглэгдэхүүнд эрүүдэн шүүхийг хориглох тухай сургалт, мэдээллийг бүрэн тусгахыг заасан нь туйлын хориглох зарчмын нэг хэсэг юм.

Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протокол болон ХЭҮКтХ-аар олгогдсон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ конвенцын 15 дугаар зүйл болон хуулийн 33.1.2; 33.1.3 заалтуудын дагуу олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах; эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах үүрэг хүлээсэн тул конвенцын уг зорилго хангагдсан гэж үзэж байна.

2.2. “ҮР ДҮНТЭЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ”: Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц нь Оролцогч улсуудад эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авах, үүний тулд үндэсний хэмжээнд хараат бусаар тогтмол хяналт шинжилгээ хийх бүрэн эрхтэй Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага байгуулж, Нэмэлт протоколын дагуу ажиллуулахыг үүрэг болгосон. Конвенц нь Оролцогч улсын авах ёстой арга хэмжээг нэг бүрчлэн жагсаадаггүй бөгөөд зөвхөн арга хэмжээ нь бодитой, үр дүнтэй байхыг шаарддаг.

Монгол Улсын ХЭҮКтХ-ийн 31.1 дэх заалтад “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн хэрэгжүүлнэ” гэж заасан бол Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбоотой төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаалд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг хамруулжээ.

Нэгдүгээр бүлэгт: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын нийцэлд дүн шинжилгээ хийсэн ба Монгол Улсын конвенцоор хүлээсэн “урьдчилан сэргийлэх” үүргийн хуулийн зохицуулалт уг бүлэгт агуулагдсан.

2.3. “ЭРҮҮДЭН ШҮҮСЭН БҮХ ҮЙЛДЛИЙГ ОРХИГДУУЛАЛГҮЙ ШАЛГАЖ, ЯЛ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ”: Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг шалгаж, шийтгэл оноох ёстой. Оролцогч улс эрүүдэн шүүхтэй холбоотой бүх үйлдлийг гэмт хэрэг хэмээн үзэж, дотоодын хууль тогтоомждоо тусгах (4 дүгээр зүйл), бүх гомдлыг шалгах ёстой (5-9, 12-13 дугаар зүйл). Эрүүдэн шүүсэн гэж үзэх үндэслэлтэй бол гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагад татах ёстой.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.12, 6.6.1.1, 10.1.2.12, 11.1.2.3, 12.1.2.8, 16.7.1 заалтууд нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын “Эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг орхигдуулахгүй шалгаж, ял шийтгэл оногдуулах” зарчимд нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

Монгол Улс нь Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд Эрүү шүүлт тулгах үйлдлийг гэмт хэрэгт тооцож тодорхойлохдоо “Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаар илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол...” гэсэн нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 1 дүгээр зүйлд нийцсэн боловч, төрийн албан тушаалтан, албаны үүрэг гүйцэтгэж буй бусад этгээд, тэдгээрийн өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр үйлдэгдэх, эрүү шүүлтэд тооцогдохгүй хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх үйлдлийг орхигдуулснаар 16 дугаар зүйлийн дагуу эдгээр үйлдлийг “эрүүдэн шүүх” гэмт хэргийн нэгэн адил тооцох зарчмыг хангаагүй байна. Ийнхүү “эрүүдэн шүүх” гэмт хэргийн бусад элементүүдийг орхигдуулан тодорхойлсон нь конвенцын 4 дүгээр зүйлээр хүлээсэн “эрүүдэн шүүх бүх үйлдлийг эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг хэмээн үзэж, ял шийтгэл оногдуулах” үүргээ Монгол Улс шударгаар биелүүлэх “амлалт”-аа зөрчсөн гэх дүгнэлтэд хүргэж байна.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 4 дүгээр зүйл нь эрүүдэн шүүх гэмт хэрэгт хамаатай хэнийг ч ял шийтгэлгүй орхигдуулахгүй байх зарчмыг агуулжээ. Уг зүйлийн дагуу эрүүдэн шүүхийг завдах, түүнд оролцох, хамтран оролцох үйлдэл ч гэмт хэрэгт тооцогдох учиртай.

Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл нь эрүүдэн шүүх гэмт хэрэгт хамаатай хэнийг ч ял шийтгэлгүй орхигдуулахгүй байх энэ зарчмыг хангаагүйн дээр, эрүүдэн шүүхийг завдах үйлдлийг гэмт хэргийн зүйлчлэлд тусгаагүй байгаа нь анхаарал татаж байна.

Конвенцын 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “ийм гэмт хэрэг үйлдэгчид хэргийн нөхцөл байдлыг нь харгалзан зохих шийтгэл ногдуулна” гэсэн нь эрүүдэн шүүсэн, эрүүдэн шүүхийг завдсан, хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцсан, шийтгэсэн, эдгээр гэмт хэргүүдийг хийхэд оролцсон, хамтран оролцсон хэнийг ч болов орхигдуулалгүй, гэмт хэргийн шинж чанарт нь тохирсон ял, шийтгэл оногдуулах агуулгыг илэрхийлжээ.

Гэтэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл нь эрүүдэн шүүх гэмт хэргийн бүх элементийг агуулалгүй тодорхойлсноороо зөвхөн “эрүүдэн шүүсэн” гэмт хэрэгт, түүнийг үйлдсэн төрийн албан хаагчид торгох болон хорих ял оноохоор хуульчилсан нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор хүлээлгэсэн дээрх үүрэг, зарчим, шаардлагуудад нийцээгүй эрх зүйн зохицуулалт болсныг илтгэж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд “эрүүдэн шүүх” үйлдлийг 6.6.1.1 заалтаар эрүүгийн хариуцлагын хүндрүүлэх нөхцөлд тооцсон ба 10.1.2.12 заалтаар хүний амьд явах эрхийн эсрэг, 11.1.2.3 заалтаар хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 12.1.2.8 заалтаар хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын

эсрэг, 16.7.1 заалтаар хүүхдийн эсрэг гэмт хэргүүдийн хүндрүүлэх нөхцөл байхаар тусгажээ.

Хуулийн энэ зохицуулалт нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор тодорхойлсон “бие даасан” гэмт хэргийн зүйлчлэлийн ач холбогдлыг алдагдуулж, тодорхойгүй байдал үүсгэсэн байна.

Иймд Эрүүгийн хуульд “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг” гэх бие даасан бүлэг нэмэх замаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 1, 16, 4 дүгээр зүйлүүдэд бүрэн нийцүүлэн “эрүүдэн шүүх” гэмт хэргийг оновчтой тодорхойлж, гэмт хэрэг үйлдсэн хэнийг ч болов ял шийтгэлгүй орхихгүй байх зарчмыг ханган, ял шийтгэлийг чангатгах, хуульд зүйлчилсэн бусад гэмт хэргүүд нь “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг” бүлэгт хамаарах хэргийн хүндрүүлэх нөхцөл байхаар тусгах нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Монгол Улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.5, 1.6, Тусгай ангийн 251, 251.2, 251.3, Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14, ЭХХШТХ-ийн 15.1.2, 31.8.1.8, Өршөөл үзүүлэх тухай хуулийн 9 заалтууд нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын холбогдох зарчимд нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 5, 6, 9, 12 дугаар зүйл нь эрүүдэн шүүх гэмт хэргийг шүүн таслах ажиллагааг зохицуулсан бол 13 дугаар зүйл нь “...эрүүдэн шүүгдсэн хэмээн мэдүүлж буй этгээд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах явдлыг хангана. Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ” авахыг Оролцогч улсуудад үүрэг болгосон.

Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.5; 1.6 дугаар зүйлүүдэд Эрүүгийн хуулийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадна үйлчлэх зохицуулалтыг хуульчилсан нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 5, 6, 9, 12 дугаар зүйлүүдэд бүрэн нийцжээ.

Монгол Улс нь конвенцын 13 дугаар зүйлийн “гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах” эрхийн хэрэгжилтийг хангах хуулийн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14; ЭХХШТХ-ийн 15.1.2 болон 31.8.1.8 заалтуудад тусгасан боловч “гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ” авах үүргийн зохицуулалтыг орхигдуулжээ.

Ийнхүү орхигдуулсан нь “эрүүдэн шүүх” гэмт хэргийн илрүүлэлтэд сөргөөр нөлөөлөх, удаашрах, тогтолцооны түвшинд оршсоор байх нөхцөл болжээ. Иймд Эрүүгийн хуульд “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг” хэмээх бүлгийг хуульчлахдаа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 13 дугаар зүйлийн заалтуудад бүрэн нийцүүлэх нь чухал юм.

Өршөөл үзүүлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлээр “Өршөөл хамааруулахгүй гэмт хэрэг, эрүүгийн хариуцлагын төрөл”-д 2002 оны Эрүүгийн хуулийн 251, 251.2, 251.3-т заасан “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийг хамруулсан бол 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 21.12 заалтыг уг зүйлд тусгаагүй тул өршөөлд хамрагдах боломжтой гэмт хэргийн төрөл болсон байна.

2.4. ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ХОХИРОГЧДОД ШУДАРГА, ХАНГАЛТТАЙ НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ: Эрүү шүүлтийн хохирогчид хохирлоо арилгуулах боломжтой байх ёстой бөгөөд эрүүл мэндээ бүрэн сэргээх хэлбэрийг оролцуулан шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх эдлэх ёстой (14 дүгээр зүйл). Эрүүдэн шүүгдсэний улмаар хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14, ЭХХШТХ-ийн 45.1, 45.2.1, 45.2.2.5, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.3 заалтууд нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын холбогдох зарчимд нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

Монгол Улс нь Үндсэн хуулийн 16.14 дүгээр зүйлээр “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх”, ЭХХШТХ-ийн 45.1 дүгээр зүйлээр “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэндийн хохирол, сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлүүлэх болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх” эрхийн баталгааг хангаж, ЭХХШТХ-ийн 45.2.1 заалтаар “эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан”, 45.2.2.5-д зааснаар “яллагдагчийг эрүүдэн шүүсэн болох нь нотлогдсон тохиолдолд” төр хариуцан арилгахаар тусгаж, ингэхдээ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10.3 заалтаар “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Эрүүгийн хуулийн ... 21.12 /Эрүү шүүлт тулгах/-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан ... хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна” хэмээн хуулийн зохицуулалт хийсэн нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 14 дүгээр зүйлд нийцжээ.

Мөн Шүүх шинжилгээний тухай хуулийн 40.1 заалтаар “Шинжилгээний байгууллага Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/-д заасан гэмт хэргийн улмаар хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргана” гэж заажээ.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Монгол Улсын ЭХХШТХ-ийн 45.4, Иргэний хуулийн 228, 229, 230 заалтууд нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын холбогдох зарчимд нийцүүлэн эрх зүйн зохицуулалт хийх зорилгодоо хүрсэн эсэх?

Харин ЭХХШТХ-ийн 45.4 дүгээр зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцэд учирсан хор уршгийг арилгуулах, нөхөн төлүүлэх талаар нэхэмжлэл гаргаагүй, эсвэл ... иргэний нэхэмжлэлийн тооцоо гаргах бололцоогүй тохиолдолд нөхөн төлүүлэх төлбөрийг тогтоохдоо Иргэний хууль, шүүхийн шийдвэр, практикт үндэслэн жишиг хэмжээгээр тогтоох тухай заасан байна.

Иргэний хуулийн 228 дугаар зүйл нь гэм хорыг арилгуулах эрхийг, 229 дүгээр зүйл нь гэм хорыг арилгах хэмжээг, 230 дугаар зүйл нь эдийн бус гэм хорыг арилгах ажиллагааг тус тус зохицуулсан нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцсан, шийтгэсэн

гэмт хэргийн хохирогчдод шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх зүйн орчныг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод нийцүүлэн бүрдүүлжээ.

Хэдий тийм боловч сэтгэл ханамжийг хангах, дахин давтагдахгүй байх баталгаагаар хангах зарчим энд тусаагүй байна. Сэтгэл ханамж гэдэг нь хохирогчийн нэр төрийг сэргээх тухай албан ёсны мэдэгдэл, олон нийтийн өмнө уучлалт гуйх, хохирогчдын дурсгалыг хүндэтгэх, хүндэтгэл үзүүлэх зэрэг бусад арга хэмжээг багтааснаар хангагдах тул Эрүүгийн хууль, ЭХХШТХ, Иргэний хууль болон бусад холбогдох эрх зүйн актад хохирогчдод сэтгэл ханамжийн баталгааг хангах эдгээр арга хэлбэрийг тусгах нь зүйтэй.

3. КОНВЕНЦООР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ ЗОРИЛГООР АВСАН АЛХМУУДАА ТОДОРХОЙЛСОН ТАЙЛАНГ ГАРГАЖ БАЙХ: Оролцогч бүх улс конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан алхмуудаа тодорхойлсон тайланг гаргаж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд хүргүүлдэг байх ёстой. Конвенцын 19 дүгээр зүйлд заасны дагуу Оролцогч улс соёрхон баталснаас хойш нэг жилийн дотор Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд анхны тайлангаа өгөх ёстой. Үүнээс цааш тогтмол тайлангуудыг дөрвөн жил тутамд гаргана.

Монгол Улс нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын оролцогч болохынхоо хувьд 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр соёрхон баталснаасаа хойш нэг жилийн дотор НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд уг конвенцоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн анхдугаар илтгэлийг тавих ёстой байсан боловч 2009 онд хүргүүлжээ. Улмаар 2 дахь илтгэлийг 2015, 3 дахь илтгэлийг 2020 онд Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд уламжилсан байна.

ТАВ. ЯАГААД ЭРҮҮДЭН ШҮҮЛТИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛД ДОТООДЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙГ НИЙЦҮҮЛЭХ ЁСТОЙ ВЭ?

Монгол Улсын Үндсэн хууль

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”

Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нэгдэн орж, Улсын Их Хурал тус тус соёрхон баталсан.

Иймд соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон үүргийнхээ дагуу дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасан тул Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол дотоодын хууль тогтоомжтой адил үйлчилнэ.

I. “ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ” ГЭМТ ХЭРГИЙН ТОДОРХОЙЛОЛТ ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙД ТУСГАГДСАН НЬ⁷⁴

НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц

1 дүгээр зүйл

1. Энэхүү Конвенцын зорилгын дагуу “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолт нь хуулийн дагуу авах шийтгэл, арга хэмжээ, түүнээс үүдэн буюу холбогдон үүсэх зовлон, шаналалд хамаарахгүй.

16 дугаар зүйл

1. Оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ 1 дүгээр зүйлд тодорхойлсон эрүү шүүлтэд тооцогдохгүй төрийн албан тушаалтан буюу албаны үүрэг гүйцэтгэж буй бусад этгээд, тэдгээрийн өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр үйлдэгдэх хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх бусад үйлдлээс сэргийлэх үүрэг хүлээнэ. Түүнчлэн 10, 11, 12, 13 дугаар зүйлд заасан үүргүүдийг бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх тохиолдолд орлуулан хэрэглэнэ.

Гол элементүүд

НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц нь ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ⁷⁵ үйлдлийг дараах 3 шинж чанарыг агуулсан гэж тодорхойлсон.

- Сэтгэцийн болон бие махбодын хүнд дарамтыг санаатайгаар учруулсан
- Төрийн албан тушаалтан шууд болон шууд бусаар холбогдсон
- Тодорхой зорилго агуулсан

Зарим бүс нутгийн конвенцод эрүү шүүлт тулгах үйлдлийг илүү өргөн хүрээтэй тодорхойлсон байдаг. Жишээлбэл, Америк хоорондын конвенцод эрүү шүүлтийн тодорхойлолт нь хохирогчид учруулсан өвдөлт, зовлонг «хүнд» гэж тодотгоогүй, мөн тодорхой зорилго агуулсан гэхээсээ илүү «өөр ямар нэгэн зорилгын тулд» гэж, «хохирогчийн хувийн шинж чанарыг доройтуулах, түүний бие бялдар, оюун санааны чадавхыг бууруулах зорилготой» аргууд нь өвдөлт, зовлон зүдүүр үүсгэж байгаагаас үл үл хамааран “эрүү шүүлт тулгах” үйлдэл болно гэж тодорхойлсон байдаг.

⁷⁴ <https://www.ap.t.ch/sites/default/files/publications/opcat-briefing-on-npm-designation-en.pdf>

⁷⁵ Torture

Эрүү шүүлт тулгах нь хүний нэр төрд халдсан ноцтой гэмт хэрэг бөгөөд хэзээ ч зөвтгөгдөх ёсгүй үйлдэл юм. Дайн, онц байдал болон улс орны тогтвортой байдалд заналхийлсэн бусад нөхцөлд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус харьцах, шийтгэхийг хориглодог. Энэ хориг нь туйлын бөгөөд ямар ч үед үгүйсгэгдэх ёсгүй эрх зүйн зарчим юм.

Эрүү шүүлт тулгах, хэрцгий⁷⁶, хүнлэг бус харьцах⁷⁷, шийтгэх⁷⁸ үйлдэл нь хүний бие махбодь болон сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох шинжтэй бөгөөд санаатай, тодорхой зорилгын үүднээс үйлдэгддэг. Үүнд эрх чөлөөгөө хасуулсан этгээдийг заналхийлэх, зодох, хүч хэрэглэх зэрэг үйлдлүүд хамаарахаас гадна хууль ёсны, эрх чөлөөг хасуулснаас бусад эрхийг эдлүүлэхгүй байх тухайлбал хоол, уух зүйлээр хангахгүй байх, ариун цэвэр сахиах нөхцөлийг хаан боогдуулах зэрэг үйлдлүүд нь хамаарна.

Зарим үйлдлүүд дангаараа эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт тооцогддог. Тухайлбал өлсгөж цангаах, даралттай хүйтэн усаар шүрших, цахилгаанаар цохиулах, гарыг нь ар нуруунд нь гавлаж дүүлжлэх болон хүчиндэх зэрэг үйлдлүүд.

Эрүү шүүлт тулгах, хэрцгий, зүй бус харьцах, шийтгэх гэмт хэрэг нь цаг хугацааны явцад өөрчлөгддөг ойлголтууд юм: урьд нь хэрцгий, хүнлэг бус харьцсан гэж үзэж байсан үйлдэл эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт шинээр тооцогдож болно.

II. “ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУС, ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАХ, ШИЙТГЭХ” ГЭМТ ХЭРГИЙН ТОДОРХОЙЛОЛТ ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙД ТУСГАГДСАН НЬ

Эрүү шүүлт тулгахаас ялгаатай нь хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх гэмт хэргийн тодорхойлолтыг олон улсын ямар ч гэрээнд тусгаагүй. Тиймээс ч олон улсын шүүх болон гэрээний байгууллагууд энэ гэмт хэргийн тухайд баримтлах үзэл баримтлалыг тодруулахыг оролдсон. Юуны өмнө «хэрцгий» ба «хүнлэг бус» гэсэн ойлголтууд ижил утгатай юм.

Олон улсын хүний эрхийн эрх зүйд хэрцгий, хүнлэг бусаар харьцах нь санаатай болон хайхрамжгүй байдлаас болж сэтгэл санааны болон бие махбодид ноцтой хохирол учруулах, төрийн албан тушаалтан шууд болон шууд бусаар холбогдох гэмт хэрэг хэмээн тодорхойлдог.

Аливаа үйлдлийг хэрцгий, хүнлэг бус гэж үзэхийн тулд зорилтот элемент шаардлагагүй. Энэ нь нэг үйлдэл/эс үйлдэхүйн үр дүнд үйлдэгдсэн байж болно, эсвэл хэд хэдэн үйлдэл/эс үйлдэхүйн хослолын үр дүнд үүсч болно. Үйлдлийг тусад нь хэрцгий, хүнлэг бус шинжтэй гэж авч үзэх боломжгүй.

Хэрцгий буюу хүнлэг бус харьцах арга хэлбэр нь: Хүчээр алга болсон хохирогчдын гэр бүлийн гишүүдийн сэтгэл санааны зовлон шаналал; эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхгүй байх, эсвэл эмчилгээг буруугаар ашиглах; зохисгүй нөхцөлд цагдан хорих, саатуулах; бие махбодийн хүчирхийллийг санаатайгаар ашиглах гэх зэрэг.

⁷⁶ Cruel

⁷⁷ Inhuman treatment

⁷⁸ Punishment

Хүний нэр төрийг доромжлох нь хэрцгий, хүнлэг бусаар харьцах, шийтгэх гэсэн ойлголтоос ялгаатай. Хүний нэр төрийг доромжлох гэмт хэргийн үзэл баримтлалд нэн чухал зүйл бол хүчтэй шаналал үүсгэх байдал биш, харин хүнийг доромжлох, гутаах зорилго юм.

Хүний нэр төрийг доромжлох нь: бусдын өмнө хувь хүнийг бүдүүлгээр доромжлох, хоригдолд бохирдсон хувцсаа солихыг зөвшөөрөхгүй байх, зохисгүй нөхцөлд цагдан хорих, саатуулах гэх мэт.

III. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ АЖИЛЛАГААНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙД ТУСГАГДСАН НЬ⁷⁹

Юуны өмнө Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны гишүүд, ажилтнууд, мэргэжилтнүүд биечлэн болон байгууллагын хувьд төрийн эрх мэдлээс хараат бус байх шаардлагатай.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол нь Оролцогч улсууд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны бие даасан байдлыг бүхэлд нь баталгаажуулж, бие даасан ажилтнуудаас бүрдүүлэхийг баталгаажуулахыг шаарддаг (Нэмэлт протоколын 18 дугаар зүйл. 1 дүгээр хэсэг). Практикт хараат бус байдал гэдэг нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь төрийн эрх баригчдын хөндлөнгийн оролцоогүйгээр ажиллах чадвартай байх ёстой гэсэн үг юм.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хараат бус байдалд улс төрийн намуудын хөндлөнгийн оролцоог ч үл тэвчих ёстой. Мөн шүүх болон эрүүгийн эрх зүйн тогтолцооны бусад оролцогчдоос хараат бус байх шаардлагатай.

Бүрэн эрх

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны хараат бус байдал болон ажилтнуудын бие даасан байдлыг баталгаажуулах нь Нэмэлт протоколд оролцогч улсуудын хүлээсэн үүрэг⁸⁰ юм. Нэмэлт протоколд оролцогч улсууд Парисын зарчмуудыг зохих ёсоор анхаарч, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг байгуулахдаа Дэд хорооноос Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд зориулан гаргасан Удирдамжийг мөрдлөг болгохыг зөвлөдөг. Бие даасан байдал нь хуулиар олгогдсон бүрэн эрх, үйл ажиллагааны болон санхүүгийн хараат бус байдлыг багтаадаг.

Хуулиар олгогдсон бүрэн эрх нь Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжийн бичвэрт тусгагдсан байх ёстой. Энэ бүрэн эрхэд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны гишүүдийн эрх мэдэл, сонгон шалгаруулах үйл явц, бүрэн эрхийн хугацаа, санхүүжилт, хэрэгжүүлэх чиг үүрэг, үүрэх хариуцлагын чиглэлийг зааж өгөх ёстой. Мөн хяналт шинжилгээ хийх, мэдээлэл авах, зөвлөмж өгөх, Дэд хороотой харилцах зэрэг эрх мэдлийг олгох ёстой.

⁷⁹ NPM_Guide_EN.pdf (ohchr.org)

⁸⁰ НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын 18.1-р заалт



Үйл ажиллагааны бие даасан байдал

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүргийн хэрэгжилт бие даасан байдалтай байх ёстой. Төрийн гүйцэтгэх засаглалын байгууллагын хяналтаас гадуур байх учиртай. Мөн байгуулагдсан бүтцээс шалтгаалан харьяа байгууллагаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд түүний бүрэн эрх, үйл ажиллагаанд тухайлбал, ажилтнуудад нь үүрэг даалгавар өгөх, бүрэн эрхийг нь өөрчлөх гэх зэргээр хөндлөнгөөс оролцохгүй байх ёстой ба энэ тухай хуульд тодорхой зааж өгөх ёстой.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанаас гомдол шалган шийдвэрлэх, захиргааны бусад чиг үүрэг зэрэг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколоор олгосон бүрэн эрхтэй зөрчилдөж болзошгүй нэмэлт үүрэг даалгавар хэрэгжүүлэхийг шаардах ёсгүй.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь үйл ажиллагааныхаа бие даасан байдлыг хангахын тулд дотоод дүрэм, журмыг боловсруулах, мөрдөх онцгой эрхтэй байх ёстой.

Санхүүгийн бие даасан байдал

Оролцогч улсууд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг үр дүнтэй, бие даасан байдлаар ажиллуулах, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколын дагуу чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийн хуваарилалтыг хуулийн зохицуулалтаар хийх үүрэгтэй. Санхүүгийн бие даасан байдал нь бие даасан байдлын үндсэн, урьдчилсан нөхцөл юм. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг байгуулах тухай хууль тогтоомжид тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр, мөн чанарын тухай заалтуудыг тусгаж, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд жил бүрийн санхүүжилт олгох үйл явцыг тодорхой зааж өгөх ёстой.

Төсвийн хуваарилалтын үе шатууд дараах байдалтай байж болно.

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь өөрийн ажлын төлөвлөгөөний дагуу жилийн төсвөө гаргах.
2. Хэрэв ХЭҮБ-ын дэргэд байгуулагдсан бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсвийг уг байгууллагаас тусад нь боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх ёстой.
3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны дарга/гишүүн УИХ-д төсвөө танилцуулах.
4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь нийт хуваарилсан төсвийн хүрээнд зардлын тэргүүлэх чиглэлээ өөрсдөө тодорхойлох эрхтэй.

Хүний нөөцийн бие даасан байдал

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа нь гадны оролцоогүйгээр хүний нөөцөө өөрсдөө сонгох ёстой. Албан хаагч нь хууль эрх зүй, эрүүл мэндийн болон бусад холбогдох чиглэлээр мэргэшсэн байх, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай олон талын мэдлэг, чадвар, мэргэжлийн мэдлэгтэй байх ёстой.

ЭШУС үндэсний ажиллагаа ба Хүний эрхийн Үндэсний Байгууллага хоорондын харилцаа

Хүний эрхийн үндэсний байгууллагад (ХЭҮБ) нэмэлт үүрэг олгож, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны чиг үүрэг хэрэгжүүлэхээр томилсон тохиолдолд НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо энэ хоёр байгууллагыг тусдаа зохион байгуулалтын нэгж болгон, уг нэгжийг үйл ажиллагааны хувьд бие даасан, хараат бус эрх бүхий дарга /манай улсын тухайд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн/ удирдан ажиллахыг зөвлөдөг.

Эцсийн дүндээ, ХЭҮБ-ын байгууллагын бүтэц нь Нэмэлт протоколын шаардлагыг тусгах ёстой бөгөөд үүнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны үйл ажиллагааны, санхүүгийн, хүний нөөц, ажлын удирдлага, зохион байгуулалт, дүгнэлт, зөвлөмж, Дэд хороотой шууд (шаардлагатай бол нууц) харилцах зэрэг үйл ажиллагааны бие даасан байдал багтсан байх ёстой.

Гурав. Монгол Улсын холбогдох хуулиуд нь нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцоор хүлээсэн үүргийг хэм хэмжээг хангаж, түүнд нийцсэн эсэхэд судалгаа хийж дараах дүгнэлтэд хүрлээ.

Хүснэгт 4. Үнэлгээний хураангуй

№	Үнэлэх хууль, түүний зүйл, заалт	Зорилгод хүрсэн байдал
1	Монгол Улсын Үндсэн Хууль - 16.13	Тийм
2	Монгол Улсын Үндсэн Хууль - 19.2	Тийм
3	Онц байдлын тухай хууль - 18	Тийм
4	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 1.9.1	Тийм
5	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 1.9.2	Тийм
6	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 16.14.4	Тийм
7	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 29.5.1.1	Тийм
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - 7.3	Тийм
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - 273.2.2	Тийм
10	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - 273.2.7	Тийм
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - 273.2.12	Тийм
12	Цагдаагийн албаны тухай хууль - 22.4	Тийм
13	Цагдаагийн албаны тухай хууль - 69.1.2	Тийм
14	Цагдаагийн албаны тухай хууль -69.1.7	Тийм

15	Цагдаагийн албаны тухай хууль - 69.1.12	Тийм
16	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль - 3.2	Тийм
17	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль - 4.8.7	Тийм
18	Гамшгаас хамгаалах тухай хууль - 10.9.4	Тийм
19	Короновируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль - 11.1.4	Тийм
20	Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль - 3.2	Тийм
21	Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хууль - 7.1.7	Үгүй
22	Эрүүгийн хууль - 1.7.3	Тийм
23	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 43.3.1.6	Тийм
24	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 16.12.1	Үгүй
25	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 16.12.2	Үгүй
26	Эрүүгийн хууль - 21.12	Үгүй
27	Эрүүгийн хууль - 6.6.1.1	Үгүй
28	Эрүүгийн хуулийн Ерөнхий анги -1.5	Тийм
29	Эрүүгийн хуулийн Ерөнхий анги - 1.6	Тийм
30	Монгол Улсын Үндсэн хууль - 16.14	Тийм
31	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 15.1.2	Тийм
32	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 31.8.1.8	Тийм
33	Өршөөл үзүүлэх тухай хууль - 9 дүгээр зүйл	Тийм
34	Монгол Улсын Үндсэн хууль - 16.14	Тийм
35	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 45.1	Тийм
36	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 45.2.1	Тийм
37	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 45.2.2.5	Тийм
38	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль - 10.3	Тийм
39	Шүүх шинжилгээний тухай хууль - 40.1	Тийм
40	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль - 45.4	Тийм
41	Иргэний хууль - 228	Тийм
42	Иргэний хууль - 229	Тийм
43	Иргэний хууль - 230	Тийм
НИЙТ/ХУВЬ		38/5
		88,3%

Монгол Улс нь НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод нэгдэн орсноор түүгээр хүлээсэн эрүүдэн шүүхийг хориглох, урьдчилан сэргийлэх, энэ үйлдлийг гэмт хэрэгт тооцон шийтгэх, энэ үйлдлийн хохирогчдод нөхөн төлбөр олгох үүргийг холбогдох хуулиудад тусгахдаа конвенцын хэм хэмжээний шаардлагад хэрхэн нийцүүлсэн байдалд дүн шинжилгээ хийж, нийт 16 хуулийн 43 заалтаар үнэлэхэд Зорилгод хүрсэн байдал нь 88,3 хувь байна.

Монгол Улс Үндсэн хууль болон бусад 9 бие даасан хуулийн 20 заалтаар эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг доромжлохыг хориглосон нь НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын “туйлын хориглох” зарчмыг хангажээ.

Гэвч ийнхүү эрүүдэн шүүх үйлдлийн туйлын хориглолтыг ЭХХШТХ, ШШГТХ, Цагдаагийн албаны тухай хуулиудаар шүүх эрх мэдлийн, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан тушаалтнуудад хамаатуулсан боловч бусад чиг үүргийн төрийн болон хувийн хэвшлийн бусад байгууллагын албан хаагч, ажилтан, хуулийн этгээдэд хориглох зохицуулалтыг холбогдох хуулиудад тусгаагүй байна.

Энэхүү дүн шинжилгээний хүрээнд анхаарал татсан хуулийн заалт нь ЭХХШТХ-ийн 16.12.1 байлаа. Уг заалт нь мөрдөн шалгах ажиллагааны үед эрүү шүүлт тулгаж мэдүүлэг авсан бол нотлох баримтад тооцохгүй байхаар тусгасан. Мөрдөн шалгах ажиллагаанд мэдүүлэг авахаас гадна баримт, мэдээлэл цуглуулах бусад 20 гаруй ажиллагааны гүйцэтгэл явагддаг. Гэтэл хуулийн уг заалтад мэдүүлэг авах процессыг хамаатуулснаар бусад ажиллагааны үед эрүү шүүлт тулгаж авсан баримт, нотолгоо нь нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх “хуулийн цоорхой”-г бий болгожээ.

Өөр нэгэн анхаарах хуулийн заалт нь Эрүүгийн хуулийн 21.12 юм.

Энэхүү заалт нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийг тодорхойлохдоо эрүү шүүлтэд тооцогдохгүй бусад үйлдлийг, тухайлбал хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх үйлдлийг нэрлэлгүй орхигдуулсан нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын “эрүүдэн шүүх бүх үйлдлийг эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг хэмээн үзэж, ял шийтгэх оногдуулах” зарчимд нийцээгүй байна.

Мөн заалт нь гэмт хэрэгт тооцох уг үйлдлийг үйлдсэн этгээдэд үйлчлэхээр байгаа боловч эрүүдэн шүүхийг завдсан, түүнд оролцсон, хамтран оролцсон үйлдлийг нэрлээгүй байгааг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын “эрүүдэн шүүх гэмт хэрэгт хамаатай хэнийг ч ял шийтгэлгүй орхигдуулахгүй байх” зарчим хангагдаагүй гэж дүгнэгдэж байна.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Оролцогч улсуудад хүлээлгэж байгаа гол үүрэг нь эрүүдэн шүүх үйлдлийг “бие даасан” эрүүгийн хэрэгт тооцож, түүнийг үйлдсэн этгээдийг эрүүгийн хуулиар шийтгэх явдал юм.

Гэтэл Монгол Улсын Эрүүгийн хуульд “эрүүдэн шүүх” үйлдлийг бусад 5 төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд тооцсон нь “бие даасан” эрүүгийн хэргийн мөн чанарыг алдагдуулсан зохицуулалт болжээ.

Угтаа, бусад 5 төрлийн гэмт хэргийг үйлдсэнээр эрүүдэн шүүсэн бол хүндрүүлэх нөхцөлд тооцохоор зохицуулах нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын зарчимд нийцэх учиртай.

Монгол Улсын холбогдох хуулиуд конвенцын 13 дугаар зүйлээр хүлээсэн “гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах” эрхийг хангасан боловч гомдол гаргасан, нотлох баримт гаргасныхаа төлөө зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэлтээс хамгаалагдах хуулийн хамгаалалтыг хийгээгүй орхигдуулсан нь дараагийн анхаарах том асуудал юм.

Нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцоор хүлээсэн үүргийн хэм хэмжээ Монгол Улсын хууль, эрх зүйн орчинд хангалттай тусгалаа олсон нь сайшаалтай боловч ялангуяа “эрүүдэн шүүх” гэмт хэргийг конвенцын зарчимд нийцүүлэн оновчтой тодорхойлох, энэ гэмт хэргийн “бие даасан” зүйлчлэлд гэмт хэргийн бүхий л элемент, оролцооны шинж чанар, субъект гээд конвенцод агуулж буй зарчмуудыг хангаж, нийцүүлэх зүй ёсны шаардлага үүссэнийг энэхүү дүн шинжилгээ харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Эрүүгийн хуульд “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийг “бие даасан” бүлэг болгон зүйлчлэх. Ингэхдээ хуульд зүйлчилсэн бусад гэмт хэргүүд нь “Эрүү шүүлт тулгах” гэмт хэрэг бүлэгт хамаарах хэргийн хүндрүүлэх нөхцөлд тооцохоор тусгах;
2. Мөн хуулийн “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн тодорхойлолтыг НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод бүрэн нийцүүлэх. Ингэхдээ:
 - a. Энэ эрүүдэн шүүхийг завдах, үйлдэхэд оролцох, хамтран оролцох үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцох;
 - b. Эрүүдэн шүүх гэмт хэргийн бүхий л элементийг “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн нэгэн адил гэмт хэрэгт тооцох;
 - c. Одоогийн зохицуулалтаар төрийн албан хаагч нь “эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн субъект болохоор заасан байгааг өөрчилж, хүний эрх чөлөөг хасах, хязгаарлах бусад чиг үүргийн төрийн байгууллага, хувийн хэвшлийн албан тушаалтан, ажилтан, хуулийн этгээдийг эл гэмт хэргийн субъектэд тооцох;
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.12.1, 16.12.2 заалтуудыг нэмэлт өөрчлөлт оруулах замаар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын зарчимд нийцүүлэн мөрдөн шалгах ажиллагааны бүхий л процесст эрүү шүүлт тулгаж олж авсан тайлбар, мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй байхаар хуульчлах;
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүдэн шүүгдсэн гэх гомдол гаргасан болон энэ гэмт хэргийн талаарх нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг тусгах;
5. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Иргэний хуулиудад эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийн сэтгэл ханамжийг хангах, дахин давтагдахгүй байх баталгаагаар хангах зохицуулалтыг хийх. Ингэхдээ:
 - a. Хохирогчийн нэр төрийг сэргээх тухай албан ёсны мэдэгдэл хийх
 - b. Олон нийтийн өмнө уучлалт гуйх
 - c. Хохирогчдын дурсгалыг хүндэтгэх
 - d. Хүндэтгэл үзүүлэх бусад арга хэмжээг багтаах зэрэг.

ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН ХОЛБОГДОХ ХУУЛЬ БА ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН НИЙЦЭЛ

Хүснэгт 5. Монгол Улсын холбогдох хууль ба Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын нийцэл

	ХОРИГЛОХ		УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ		ШИЙТГЭХ		ХОХИРЛЫГ АРИЛГАХ		ТАЙЛАГНАХ	
	Нийцэл	Үл нийцэл	Нийцэл	Үл нийцэл	Нийцэл	Үл нийцэл	Нийцэл	Үл нийцэл	Нийцэл	Үл нийцэл
	Конвенцын 1, 3, 15, 10 дугаар зүйл		Конвенцын 2, 11, 16 Нэмэлт протоколын 3, 4, 17 дугаар зүйл		Конвенцын 4, 5-9, 12-13 дугаар зүйл		Конвенцын 14 дүгээр зүйл		Конвенцын 19 дүгээр зүйл Нэмэлт протоколын 23 дугаар зүйл	
Монгол Улсын Үндсэн Хууль	10.2 10.3 16.13 19.2				16.14		16.14			
Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль	33.1.2 33.1.3		НЭГ дүгээр бүлгээр дүн шинжилгээ хийсэн							
Эрүүгийн хууль	1.7.3				21.12 1.5 1.6	6.6.1.1 10.1.2.12 11.1.2.3 12.1.2.8 16.7.1				
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	1.9.1 1.9.2 16.14.4 29.5.1.1 43.3.1.6	16.12.1 16.12.2			15.1.2 31.8.1.8		45.1 45.2.1 45.2.2.5 45.4.1 45.4.2			

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль	3.2									
Өршөөл үзүүлэх тухай хууль					9.1 7.1					
Онц байдлын тухай хууль	18									
Төрийн албаны тухай хууль			13.1.3							
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	7.3 273.2.2 273.2.7 273.2.12									
Шүүх шинжилгээний тухай хууль							40.1			
Засгийн газрын тусгай сангийн тухай хууль							10.3			
Цагдаагийн албаны тухай хууль	22.4 69.1.2 69.1.7 69.1.12									
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	4.8.7									
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль	3.2									
Гамшгаас хамгаалах тухай хууль	10.9.4									
Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль	11.1.4									
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль	6.1.1 7.1.2 7.1.7									
Иргэний хууль							228 229 230			

Хүснэгт 6. Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын гэрээгээр эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг хүлээсэн үүргүүд

д/д	Гэрээ, конвенц	Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий харьцахыг хориглосон заалт
1	Хүний эрхийн түгээмэл тунхаглал ⁸¹	5 дугаар зүйл. Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцаж, шийтгэх ёсгүй.
2	Хүүхдийн эрхийн тухай конвенц ⁸²	37 дугаар зүйл. (а) хүүхдэд эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхгүй байх, 39 дүгээр зүйл. Оролцогч улсууд хүүхдийг үл хайхрах, мөлжих, зүй бусаар ашиглах, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон харьцаа, хандлага, зэвсэгт мөргөлдөөний хохирогч хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд буцаан оруулахад тус дөхөм болох шаардлагатай бүх арга хэмжээг авна.
3	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт ⁸³	7 дугаар зүйл. Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно.
4	Апартеидын гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай олон улсын конвенц ⁸⁴	2 дугаар зүйл. ... “апартеидын гэмт хэрэг” гэсэн нэр томьёо нь ... дараах үйлдлийг хэлнэ: ii/ арьс үндэстний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийн бие махбодод ноцтой гэмтэл учруулах буюу сэтгэцэд нь согог суулгах, тэдний эрх чөлөө, нэр төрд халдах, эрүү шүүлт тулгах болон хэрцгий, хүмүүнлэг бусаар хандаж харьцах, нэр төрийг нь доромжлох, шийтгэх;

⁸¹ ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ (legalinfo.mn)

⁸² ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ (legalinfo.mn)

⁸³ ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ (legalinfo.mn)

⁸⁴ АПАРТЕИДЫН ГЭМТ ХЭРГИЙГ ТАСЛАН ЗОГСООХ, ТИЙМ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧДИЙГ ШИЙТГЭХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ (legalinfo.mn)

<p>5</p>	<p>Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан болон өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн (I) конвенц⁸⁵</p>	<p><u>12 дугаар зүйл.</u></p> <p>Тэдний амь насанд халдахыг завдах, эсхүл бие махбодод халдахыг хатуу хориглоно; ялангуяа тэдний амь насыг хөнөөх буюу устгах, эрүүдэн шүүх буюу биологийн туршилт хийх;</p> <p><u>50 дугаар зүйл.</u></p> <p>Өмнөх зүйлд дурдсан ноцтой зөрчил нь энэхүү конвенцоор хамгаалагдаж байгаа этгээд буюу эд хөрөнгийн эсрэг үйлдсэн дараах аливаа үйлдлийг оролцуулсан зөрчил байна: ... эрүүдэн шүүх буюу хүнлэг бусаар харьцах, ... бие махбод буюу эрүүл мэндэд үлэмж шаналал буюу ноцтой гэмтэл санаатайгаар учруулах,</p> <p><u>1 дүгээр бүлэг. 3 дугаар зүйлийн 1</u></p> <p>Энэ үүднээс дараах үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хэзээ ч, хаана ч хийхийг хориглоно:</p> <p>(а) ... харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх;</p> <p>(с) хүний нэр төр, алдар хүндэд халдах, тухайлбал, доромжлон гутаах</p>
<p>6</p>	<p>Тэнгисийн зэвсэгт хүчний шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгсдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн (II) конвенц⁸⁶</p>	<p><u>12 дугаар зүйл.</u></p> <p>...Эдгээр этгээд мэдэлд нь байж болох мөргөлдөөнд оролцогч тал хүйс, арьс үндэс, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол болон бусад төсөөтэй шалгуурт үндэслэн ялгаварлан гадуурхалгүйгээр тэдэнтэй хүнлэг харьцан асран хамгаална. Тэдний амь насанд халдахыг завдах, эсхүл бие махбодод халдахыг хатуу хориглоно; ялангуяа тэдний амийг хөнөөх буюу хороох, эрүүдэн шүүх ... хориглоно.</p> <p><u>51 дүгээр зүйл.</u></p> <p>Өмнөх зүйлд дурдсан ноцтой зөрчил нь энэхүү конвенцоор хамгаалагдаж байгаа этгээд буюу эд хөрөнгийн эсрэг үйлдсэн дараах аливаа үйлдлийг оролцуулсан зөрчил байна: санаатайгаар амийг нь хөнөөх, эрүүдэн шүүх буюу хүнлэг бусаар харьцах...</p> <p><u>1 дүгээр бүлэг. 3 дугаар зүйл 1.</u></p> <p>Энэ үүднээс дараах үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хийхийг хэзээ ч, хаана ч хориглоно:</p> <p>(а) ... харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх;</p> <p>(с) хүний нэр төр, алдар хүндэд халдах, тухайлбал, доромжлон гутаах;</p>

⁸⁵ ДАЙНЫ ТАЛБАРТ БАЙГАА ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ШАРХТАН БОЛОН ӨВЧТӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ ЖЕНЕВИЙН (I) КОНВЕНЦ (legalinfo.mn)

⁸⁶ ТЭНГИСИЙН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ШАРХТАН, ӨВЧТӨН БОЛОН ХӨЛӨГ ОНГОЦНЫ СҮЙРЭЛД ӨРТӨГДӨГСДИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ ЖЕНЕВИЙН (II) КОНВЕНЦ (legalinfo.mn)

7	Дайнд олзлогчидтой харьцах тухай Женевийн (III) конвенц ⁸⁷	<p><u>3 дугаар зүйл.</u></p> <p>Энэ үүднээс дараах үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хийхийг хэзээ ч, хаана ч хориглоно:</p> <p>а) ... харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх;</p> <p>с) хүний нэр төр, алдар хүндэд халдах, тухайлбал, доромжлон гутаах;</p> <p><u>III анги, I хэсэг. 17 дугаар зүйл.</u></p> <p>Олзлогдогчоос ямар нэгэн мэдээлэл олж авахын тулд тэдэнд хүч хэрэглэх буюу сэтгэл санааны дарамт, эрүү шүүлт тулгаж болохгүй. Дайнд олзлогдогчид асуултад хариулахаас татгалзах тохиолдолд тэднийг айлган сүрдүүлж, доромжлон гутааж, ямар нэг хэлбэрээр мөрдөн мөшгөж, хязгаарлалт тогтоож болохгүй.</p> <p><u>87 дугаар зүйл.</u></p> <p>Ганцаараа үйлдсэн хэргийн төлөө хамтаар нь шийтгэх, бие махбодыг тарчлаах аливаа ял, нар салхи үзэхгүй харанхуй байранд хорих болон өөр ямар нэгэн хэлбэрийн эрүү шүүлт тулгах, харгис хэрцгий хандахыг хориглоно.</p> <p><u>130 дугаар зүйл.</u></p> <p>Өмнөх зүйлд дурдсан ноцтой зөрчил гэж энэхүү конвенцын ивээлд байгаа этгээд болон түүний эд хөрөнгийн эсрэг чиглэсэн дараах үйлдлийн аль нэгийг үйлдсэнийг хэлнэ: ... эрүү шүүлт тулгах, биологийн туршилт үйлдэх зэргээр хүнлэг бус харьцах, тухайлбал хүнд гэмтэл, зовуурь санаатай учруулах,</p>
---	---	---

⁸⁷ ДАЙНД ОЛЗЛОГДОГЧИДТОЙ ХАРЬЦАХ ТУХАЙ ЖЕНЕВИЙН (III) КОНВЕНЦ (legalinfo.mn)

<p>8</p>	<p>Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай Женевийн (IV) конвенц⁸⁸</p>	<p><u>147 дугаар зүйл.</u></p> <p>Өмнөх зүйлд дурдсан ноцтой зөрчил нь энэхүү конвенцоор хамгаалагдаж байгаа хүмүүс буюу эд хөрөнгийн эсрэг үйлдсэн дараах аливаа үйлдлийг оролцуулсан зөрчил байх бөгөөд тэдгээрт санаатайгаар амийг нь хөнөөх, эрүүдэн шүүх буюу хүнлэг бусаар харьцах, түүний дотор биологийн туршилт хийх, бие махбод буюу эрүүл мэндэд үлэмж шаналал буюу хүнд гэмтэл санаатайгаар учруулах,</p> <p><u>I анги. 3 дугаар зүйл.</u></p> <p>Энэ үүднээс дараах үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хийхийг хэзээ ч, хаана ч хориглоно:</p> <p>(a) ... хүнд гэмтэл учруулах, харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх;</p> <p>(c) хүний нэр төр, алдар хүндэд халдах, тухайлбал, доромжлон гутаах;</p> <p><u>32 дугаар зүйл.</u></p> <p>Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд эрх мэдэлдээ байгаа хамгаалагдсан хүмүүсийн бие махбодод хохирол учруулах буюу тэдний амийг хөнөөхөд хүргэх аливаа арга хэмжээ авахыг хориглох талаар тусгайлан хэлэлцэн тохирно. Эдгээр хориглолтод амийг хөнөөх, эрүү шүүлт тулгах, бие махбодыг зовоон тарчлаах бүх төрлийн хүчирхийлэл хамаарагдана.</p>
<p>9</p>	<p>Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцуудын Нэмэлт I протокол⁸⁹</p>	<p><u>75 дугаар зүйл.</u></p> <p>2. Иргэний, эсхүл цэргийн байгууллагын төлөөлөгчийн хэн ч дараах үйлдлийг хийхийг хэзээ ч, хаана ч хориглоно:</p> <p>(a) хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, бие махбод болон сэтгэл санаанд хүч хэрэглэх, тухайлбал:</p> <p>(ii) бие махбод болон сэтгэл санаанд аливаа төрлийн эрүү шүүлт тулгах;</p> <p>(iii) бие махбодыг зовоон тарчлаах ял ногдуулах;</p> <p>(b) хувь хүний нэр хүндийг доромжлон гутаах, тухайлбал дайрч доромжлох, биеэ үнэлэхийг албадах буюу аливаа хэлбэрээр эвгүй, зүй зохисгүй халдах;</p> <p>(e) дээр дурдсан аливаа үйлдлийг хийхээр заналхийлэх.</p>

⁸⁸ ДАЙНЫ ҮЕД ЭНГИЙН ИРГЭДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ЖЕНЕВИЙН (IV) КОНВЕНЦ (legalinfo.mn)

⁸⁹ ОЛОН УЛСЫН ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНД ХЭЛМЭГДЭГСДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ 1949 ОНЫ 8 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН ЖЕНЕВИЙН КОНВЕНЦУУДЫН НЭМЭЛТ I ПРОТОКОЛ (legalinfo.mn)

10	Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцуудын Нэмэлт II протокол ⁹⁰	<p><u>II анги. 4 дүгээр зүйл.</u></p> <p>2.Дээр заасан нийтлэг заалтыг зөрчихгүйгээр 1 дэх хэсэгт дурдсан хүмүүсийн эсрэг дараах үйлдлийг хэзээ ч, хаана ч хийхийг хориглох бөгөөд цаашид ч хориглох болно:</p> <p>(а) хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, бие махбодын болон сэтгэл зүйн байдалд халдах, ... эрүүдэн шүүх зэрэг хүнлэг бус харьцах, гэмтээх, эсхүл бие махбодыг зовоон тарчлаах аливаа бусад үйлдэл;</p> <p>(е) хүний нэр төрийг гутаах, ялангуяа басамжлан доромжлох, хүчиндэх, биеэ үнэлэхийг албадах болон бусад аливаа хэлбэрээр зүй бусаар халдах;</p> <p>(h) дээр дурдсан аливаа үйлдлийг хийлгэхээр сүрдүүлэх.</p>
----	--	--

⁹⁰ ОЛОН УЛСЫН БУС ШИНЖ ЧАНАРТАЙ ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНД ХЭЛМЭГДЭГСДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ 1949 ОНЫ 8 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН ЖЕНЕВИЙН КОНВЕНЦУУДЫН НЭМЭЛТ II ПРОТОКОЛ (legalinfo.mn)

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”

Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт протоколд нэгдэн орж, Улсын Их Хурал тус тус соёрхон баталсан.

Иймд соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон үүргийнхээ дагуу дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх үүрэгтэй. Түүнчлэн Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт: “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасан тул Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протокол дотоодын хууль тогтоомжтой адил үйлчилнэ.

Судалгааны тайлангаас...

